МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,162.294... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.07. Пүрэв. №151 (4765) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +17
Шөнө +6

УЛС ТӨР

НОГООН САНХҮҮЖИЛТИЙН АСУУДЛААР АНХ УДАА ЧУУЛАВ

II нүүрт

ДЭЛХИЙ

ФОРУМЫН ЭХНИЙ ӨДӨР 1.16 ТЭРБУМ РУБЛИЙН 11 ГЭРЭЭ ҮЗЭГЛЭЛЭЭ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Сонины үе дуусах болоогүй шүү

Н.ПУНЦАГБОЛД

10 гаруйхан жилийн өмнө бид 2, 3-хан телевиз үзэж, цөөн хэдхэн сонин уншдаг байсныг бодвол байдал 360 градус өөрчлөгдсөн. Одоо бол иргэд 100 дөхсөн телевиз, 10 гаруй өдөр тутмын сонин, мянгаар тоологдох сайтаас мэдээлэл авч байна. Дээрээс нь сошиал ертөнц бий. Фэйсбүүк, твиттерээс эхлээд мэдээлэл авч болох суваг улам л нэмэгдэж байгаа. Тэр хэрээр нийгэмд өрнөж байгаа ямар ч асуудлыг ард түмнээс нуухад хэцүү болсон. Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиалаар дамжуулж хэнийг ч “од” болгож болдог болжээ. Нөгөө талдаа ад болгоход ч ядаад байх юмгүй болжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

# МАН-ын 65 МУУР, ХУЛГАНА БОЛЖ ТОГЛОВ



Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## “ЭРДЭНЭТ”-ЭЭС зувчуулсан мөнгө ЭРГЭЖ ИРЭХ ҮҮ

“Эрдэнэт” үйлдвэрийн ажиллагсдад халуун хоолоор үйлчилж байсан “Монголиан Кетеринг” компани гэрээ дуусахаас өмнөх гурван сарын төлбөр гэж 318.3 сая төгрөг нэхэмжлэн шүүхэд хандсанаас хамаг хэрэг үүдэв. Нэхэмжлэлийн дагуу Эрдэнэтийнхэн тооцоогоо нарийвчлан нягтлахад харин ч “Монголиан Кетеринг”-ээс авлагатай болж таарчээ. 2012 онд “Эрдэнэт” үйлдвэрт хийсэн Үндэсний Аудитын газрын шалгалтын акт, нягтлан бодох бүртгэл, шилжүүлсэн мөнгөний баримтаар 2.5 тэрбум төгрөгийг “Монголиан Кетеринг”-д илүү төлсөн нь тодорхой болжээ. Өөрөөр хэлбэл хоол үйлдвэрлэгч үйлчилгээ үзүүлсэн 21 сард ажиллагсдын идээгүй хоолны мөнгийг зувчуулан уурхайчдын үйлдвэрийг хохироосон байна. Аваагүй үйлчилгээ, хэрэглээгүй зүйлийн төлөө төлсөн мөнгөө эргүүлж авах нь шударга ёсонд нийцэх нь ойлгомжтой. Тэрчлэн “Эрдэнэт” энэ мөнгийг “Монголиан кетеринг” -аас нэхэмжилжээ. Маргаан үргэлжлэн “Монголиан Кетеринг” Үндэсний Аудитын газрын актыг илт хууль бус гэж үзэн, Захиргааны шүүхэд гомдол гаргасан байна. Энэхүү маргааныг таслах хурал энэ сарын долоонд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх дээр болж, шүүгч Б.Мөнх-Эрдэнэ дэнслэх юм байна.







| | ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|
| | АМ.ДОЛЛАР | 2430.00 | 2444.00 | ФУНТ | 3129.00 | 3206.00 |
| | ЕВРО | 2867.00 | 2927.00 | РУБЛЬ | 41.40 | 43.30 |
| | ИЕН | 22.18 | 22.61 | ЮАНЬ | 369.50 | 374.00 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2442.00 | ФУНТ | 3106.00 | 3182.00 |
| ЕВРО | 2868.00 | 2928.00 | РУБЛЬ | 41.24 | 43.50 |
| ИЕН | 21.88 | 22.47 | ЮАНЬ | 369.00 | 374.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# НОГООН САНХҮҮЖИЛТИЙН АСУУДЛААР АНХ УДАА ЧУУЛАВ



Б.ЭРХЭС

Бизнес эрхлэгчдэд Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, дэмжлэг, олон улсын чиг хандлагыг таниулан, эрчим хүчний хэрэглээг бууруулах, байгальд ээлтэй бизнес эрхлэхэд шаардлагатай мэдлэг мэдээллийг хүргэж, санхүүжилтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах боломжуудыг танилцуулан, гарц шийдлийг санал болгох зорилготой Ногоон санхүүжилтийн анхдугаар чуулган өчигдөр боллоо. Хас банкнаас зохион байгуулж буй уг чуулган “Туушин” зочид буудалд болсон бөгөөд БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, Хас банкны удирдлагууд, Даян дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан болон жижиг, дунд бизнес эрхлэгчид оролцсон юм. Анхдугаар чуулганаар Уур амьсгалын ногоон сан, түүний санхүүжилт, бизнесээ хэрхэн ногооруулах, түүнд тулгарч буй асуудлууд зэрэг тодорхой сэдвүүдийн хүрээнд явагдлаа.Энэ үеэр БОАЖ-ын сайд Д.Оюунхорол Ногоон санхүүжилтийн анхдугаар чуулганыг нээж “Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал сайнгүй, ган гачиг, түймэр, үер ус зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгаль цаг уурын аюул гамшиг ойр ойрхон тохиолдож эдийн засгийн өсөлт, ард иргэдийн аж ахуй эрхлэн амьдрах боломжийг хумьж, бэрхшээл дээр бэрхшээл нэмж байна. Иймээс учраас уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдлыг зөв оношилж, сөрөг нөлөөг нь гарз хохирол багатай даван туулах, эерэг боломжийг урьдаас харж бүрэн дүүрэн ашиглах, нэг ёсондоо уур амьсгалын эргэлтгүй болсон өөрчлөлтөд дасан зохицох хэрэгцээ улам нэмэгдэж байна. Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь нийгмийн эмзэг ядуу бүлгийн иргэдэд хамгийн хүндээр тусч байгаа билээ. Дасан зохицох үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө мөнгийг Засгийн газар дангаараа хариуцах боломжгүй нь тодорхой бөгөөд олон талт хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажил юм. Иймд төр-хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлж, аж ахуйн нэгж, бизнесийн салбарын бай-гууллагууд улс орны тогтвортой хөгжлийн амин чухал энэ ажилд идэвхтэй оролцох, хувь нэм-рээ оруулах зайлшгүй хэрэгцээ гарч ирж байна. Монгол Улсын эдийн засаг хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд энэ хөтөлбөр цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээ, ногоон барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, жижиг дунд бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийг дэмжих зэрэг ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн үндсэн зорилтуудад нийцсэн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нэн чухал арга хэрэгсэл болж байна. Энэхүү чухал хөтөлбөрийг гардан хэрэгжүүлж байгаа Хас банкныханд тусгайлан баяр хүргэж амжилт хүсэхийн ялдамд, уг хөтөлбөрийн үндсэн санхүүжүүлэгч Уур амьсгалын ногоон сан, хамтран санхүүжүүлэгчид болох Даян дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан, Европын Сэргээн босголт хөгжлийн банк болон бусад түншлэгч байгууллагуудад Монгол улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна” гэсэн юм. Дашрамд дурдахад, Уур амьсгалын ногоон сан нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд байгуулагдсан шинэ төрлийн санхүүжилтийн механизм юм. Уг механизм нь хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулалт хийх замаар хүлэмжийн хийг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой. Мөн Уур амьсгалын ногоон сан нь зөвхөн тус сангаас магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудаар дамжуулан Монгол Улсын төр, олон нийт болон хувийн хэвшлээс хэрэгжүүлэх байгаль орчинд ээлтэй ногоон төслүүдийг санхүүжүүлэх аж.

> ...Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь нийгмийн эмзэг ядуу бүлгийн иргэдэд хамгийн хүндээр тусч байгаа билээ. Дасан зохицох үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө мөнгийг Засгийн газар дангаараа хариуцах боломжгүй нь тодорхой бөгөөд олон талт хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажил юм...

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

АЙЛЧЛАЛ

## Монгол банхар их хэмжээгээр авах хүсэлтэй гэв

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй Бутаны Вант Улсын Гадаад хэргийн сайд Дамчо Доржи нар өчигдөр хоёр орны хамтын ажиллагааны талаар мэдээлэл хийлээ. Ц.Мөнх-Оргил сайд, “Бутаны Вант Улс манай оронтой хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон анагаах ухааны салбарт хамтын ажиллагаагаа хөг-жүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Тухайлбал, Монголоос адуу, сарлаг, ямааны хөлдөөсөн үр, Монгол банхар их хэмжээгээр худалдан авч, малчиддаа тараах хүсэлт тавьсан.

Мөн манай АШУҮИС, ХААИС-д мэргэжилтэн бэлтгэх болон Монгол Улсад жил бүр зохион байгуулагддаг “Хааны эрэлд” цэргийн сургуульд зэвсэгт хүчнээ оролцуулах хүсэлтэй байгаа юм. Мөн Бутаны парламент Улаанбаатар хотод үүсэн байгуулагдсан “Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв”-ийг дэмжиж байгаа” гэв. Харин Бутаны Вант Улсын Гадаад хэргийн сайд Дамчо Доржи “Монголын Улсыг “Хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш төдийлөн идэвхтэй хамтарч ажиллаж чадахгүй байсан ч Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын 2016 онд Бутаны Вант Улсад албан ёсны айлчлал Шинэ Делид суугаа Монголын Элчин сайдын идэвхтэй ажиллагааны хүрээнд аялал жуулчлал, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагаа өргөжиж байгаа” хэмээлээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний аюулгүй байдлыг хэлэлцэнэ

Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын үндэсний чуулганыг энэ сарын 12-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулахаар болжээ.

Чуулганыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, Монголын хүнсчдийн холбоо, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран зохион байгуулах аж. Монгол Улсын хүнсний салбарын өнөөгийн байдлыг тодорхойлох, хүн амын гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж, шийдвэрлүүлэхэд “Монгол Улсын хүнсний аюулгүй байдал” сэдвээр хийх үндэсний чуулганы зорилго оршиж байгаа юм. Үндэсний чуулганы өмнө салбар яамны дэмжлэгтэйгээр хэд хэдэн салбар хуралдаан зохион байгуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийн санал бодлыг сонссон билээ. “Монгол Улсын хүнсний аюулгүй байдал” сэдвээр үндэсний чуулган зохион байгуулснаар хүнсний салбарын хувийн хэвшилд тулгамдсан асуудлыг хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, төрөөс авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээний саналыг боловсруулах, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг үр дүнд хүрнэ хэмээн зохион байгуулагчид үзэж байгаа юм. Үндэсний чуулганд оролцох хүсэлтэй хувь хүн, аж ахуйн нэгжийн төлөөллийг Иргэний танхимд бүртгэж эхэлжээ.

## П.Баярхүүд хариуцлага тооцохыг шаардлаа

Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү нь 2017 оны наймдугаар сарын 15-ны өдрөөс Энхтайваны Өргөн Чөлөө буюу баруун дөрвөн замаас зүүн дөрвөн замын уулзваруудад зүүн эргэхийг хориглосон зохицуулалт хийсэн нь тооцоо судалгаа дутуу, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулсан, иргэдийн зүгээс ихээхэн эсэргүүцэл, шүүмжлэл дагуулсан шийдвэр болсон тул тухайн сарын 31-ний өдөр цуцлах шийдвэр гаргасан билээ.

Тэгвэл НИТХ дахь АН-ын бүлэг Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүүг иргэд олон нийтээс санал асуулга авахгүйгээр, тооцоо судалгаагүй буруу шийдвэр гаргаж төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын төсвийн тухай хууль болон Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн дагуу ажлын хариуцлага тооцохыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболдод мэдэгдэл хүргүүлжээ.

## “Инвест Монголиа” өндөрлөлөө

Олон улсын байгууллага, гадаад дотоодын 130 гаруй зочид төлөөлөгч, 1100 орчим хөрөнгө оруулагчдыг хамарсан “Инвест Монголиа” чуулга уулзалт 11 дэх жилдээ амжилттай болж өндөрлөлөө.

Хоёр өдрийн турш үргэлжилсэн чуулга уулзалтаар Монгол Улсын эдийн засаг, банк, санхүү, дэд бүтэц, гадаадын хөрөнгө оруулалтын орчин, хэтийн төлөв, хөгжлийн бодлого болон хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг саад бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар үндсэн 15 илтгэл сонсч 30 гаруй хэлэлцүүлэг өрнүүлэв.

Энэ жилийн хувьд хөрөнгө оруулагчдын тоо болон хөрөнгө оруулалтын хэмжээ 60 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг зохион байгуулагчид дурдаж байлаа. Чуулганд оролцогсод зөвхөн уул уурхайн салбар бус эрчим хүч, дэд бүтэц, банк, санхүү, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлж, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг чухалчилж байсан юм.

Монгол Улсын улс төрийн нөхцөл байдал нь манай улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй талаар зарим төлөөлөл хэлж байлаа.

“Сэхээнд” байгаа эдийг засгаа аврах, тогтвортой өсөлтийг бий болгохын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг сэргээж чадах эсэх нь Монгол Улсын хувьд томоохон сорилт болж байна. Үүний тулд шинээр хөрөнгө оруулалт татах арга зам, боломж нөхцөлийг эрэлхийлэхээс гадна Монгол Улсад одоо байгаа хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийнхээ санал, хүсэлтийг сонсож, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх, шинэ шатанд гаргах, хөрөнгө оруулалтыг тогтвортой хадгалах нь нэн чухал гэж Монгол Улсын Засгийн газар үзэж байгаа аж.

## Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад батламж гардуулав



БСШУС-ын сайд бөгөөд БМИУЗ (Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл)-ийн дарга Г.Чулуунбаатар ЭЗҮДС, Отгонтэнгэр их сургууль, ХУИС, ОУЭЗБДС, ШУТИС-ийн Геодизи хөтөлбөрийн хамт олонд олон улсад магадлан итгэмжлэгдсэн батламжийг өчигдөр гардууллаа.

АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөл (ACBSP)-өөр магадлан итгэмжлэгдсэн Эдийн засгийн үндэсний дээд сургууль, Отгонтэнгэр их сургууль, ХУИС, ОУЭЗБДС-д тус тус батламж, гэрчилгээг гардуулсан юм. Түүнчлэн ХБНГУ-ын Инженер, мэдээлэлзүй, байгалийн ухаан, математикийн мэргэжлийн хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх агентлаг (ASIIN e.V.)-аар магадлан итгэмжлэгдсэн ШУТИС-ийн Геодизи хөтөлбөрийн хамт олонд батламж, гэрчилгээг нь гардуулав.

БМИҮЗ (Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл) АНУ-ын Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөл (ACBSP) 2009 оноос хамтран ажилласан бөгөөд 2011.11.01-ний өдөр хамтын ажиллагааны гэрээг байгуулж, 2014 оны зургадугаар сард шинэчлэн баталжээ.

Тус гэрээг байгуулснаар манай улсын эдийн засаг, бизнесийн чиглэлээр сургалт явуулдаг сургуулиуд дээрх зөвлөлтэй танилцаж, өргөн хүрээнд хамтран ажиллах боломж нээгджээ. Өнөөдрийн байдлаар монголын 14 сургууль тус зөвлөлөөр магадлан итгэмжлэгдэж, долоон сургууль нэр дэвшигч, гишүүн сургуулийн статустай, магадлан итгэмжлэлд бэлтгэж байна. Дашрамд дурдахад, АНУ-ын Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөл (ACBSP)-ийн магадлан итгэмжлэл нь олон улсад хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд дэлхийн 50 орчим улсын 1000 гаруй сургууль гишүүнчлэлтэй аж.

# МАН-ЫН 65 МУУР, ХУЛГАНА БОЛЖ ТОГЛОВ

Б.ӨНӨРТОГТОХ

УИХ-ын ээлжит бус чуулган өчигдөр хуралдаж, нэр бүхий 31 гишүүний өргөн мэдүүлсэн Засгийн газраа огцруулах асуудлыг хэлэлцэхээр 10.00 цагт хурлаа товлосон юм. Гэсэн ч хуралдааны ирц хүрэхгүй хойшилсоор өдрийн 13.00 цагт хуралдаан эхэллээ. Хамгийн сонирхолтой нь огцруулах асуудлыг өргөн мэдүүлсэн Ц.Нямдорж, Т.Аюурсайхан тэргүүтэй 31 гишүүн хуралдаа суугаагүй юм. Хуралдаан эхэлсэн даруйд УИХ-ын дарга М.Энхболд өнгөрсөн хугацаанд Засгийн газрын хийж хэрэгжүүлсэн ажлын талаар товч танилцуулав. Тэрбээр, "Өнөөдрийн ээлжит бус чуулганаар Засгийн газрыг огцруулах асуудлыг хэлэлцэх гэж байна. Энэ асуудал зөвхөн олонхийн бүлгийн дотоод маргаанаас хальж, ард иргэдийг талцуулсан, төр засагтаа үл итгэх байдал руу чиглүүлж байгаад харамсч байна" хэмээлээ. Харин Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат чуулганы танхимд үг хэллээ. Түүний хувьд шийдвэр яаж ч гарсан хүлээж авна. Гэхдээ залуу хүний хувьд журмын нөхрөө тагнаж чагнасан гэх муухай нэртэйүлдмээргүйбайгаагаахэлж байв. Ж.Эрдэнэбат сайд "Намайг огцруулахаар нэр бүхий гишүүд гарын үсэг зурсан. Гэхдээ үүний өмнө намайг Шадар сайдыгаа тагнасан гэх яриа гарсан. Эндээс болж иргэдийн дунд ч эргэлзээтэй байдал үүслээ. Би энэ асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэж өгөөч гэж хүсэлт тавьсан. Гэсэн ч хүлээж аваагүй. Одоо Тусгай хяналтын дэд хороогоор хэлэлцэж үнэн мөнийг тогтоож өгөөч гэж хүсье. Ард түмэнд зөв ойлголт өгмөөр байна. Би залуу хүн. Цаашдаа улс төрд явна. Гэтэл ийм зүйлд холбогдохыг хүсэхгүй байна. Шаардлагатай гэвэл намайг огцруулахаар санал өгсөн хүмүүст ажлаа тайлагнахад бэлэн байна. Ардын хүүхдийг алагчлахгүй мөнгө өгөх ёстой гэж шийдвэр гаргасны төлөө огцрох гэж байна. Төсөвт өртөг нь нэмэгдчихсэн, АН-ын Засгийн газрын үед хэрэгжээд эхэлчихсэн концессыг 50 тэрбумаар багасгасан гэж намайг огцруулах бололтой" хэмээлээ. Харин МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа Ерөнхий сайдын хүсэлтийг дэмжиж буйгаа илэрхийлж, ард иргэдийн дунд үүсээд буй эргэлзээтэй байдлыг арилгах, нөгөөтэйгүүр хэн нь хэнийгээ тагнаж чагнасныг тодорхой болгосны дараа Засгийн газраа огцруулах уу, үгүй юу гэдгээ шийдмээр байна хэмээгээд УИХ-ын даргаас завсарлага хүслээ. МАН-ын бүлгийн хүсэлтийг УИХ-ын дарга хүлээн авч, хуульд заасны дагуу гурван цагийн завсарлага өгсөн юм.

## УИХ–ын дарга хууль зөрчив үү

Шадар сайдыг тагнаж чагнасан асуудлаар Тусгай хяналтын дэд хороог хуралдуул хэмээн УИХ-ын дарга МАН-ын бүлэгт завсарлага өгсний дараа энэ завсарлага хууль ёсных мөн үү, биш үү гэх маргаан улстөрчдийн дунд гарсан юм. Тодруулбал, Үндсэн хуульд УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлахдаа тодорхой нэг асуудлыг хэлэлцэх ёстой аж. Нэг үгээр хэлбэл, УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн Засгийн газрыг огцруулах тухай. Огцруулах үндэслэлийн хүрээнд чуулган болон байнгын хороог хуралдуулах хуультай юм байна. Гэтэл Засгийн газрыг огцруулах үндэслэл дунд Шадар сайдаа тагнаж чагнасан гэж байхгүй учраас хууль зөрчиж, огт өөр асуудлаар Тусгай хяналтын дэд хороог хуралдуулж хууль зөрчиж байна гэх асуудал ч өрнөөд амжсан юм. Түүнчлэн, огцруулах асуудлыг өргөн мэдүүлж, Байнгын хороогоор хэлэлцсэнээс хойш долоо хоногийн хугацаанд УИХ-ын чуулганаар хэлэлцэнэ гэсэн хуулийн хугацаа өчигдөр дууссан учраас УИХ-ын дарга Үндсэн хууль зөрчил рүү явж байгааг гишүүд сануулж байв. Эдгээр маргаантай асуудлын хүрээнд хэн ямар байр сууръ илэрхийлснийг уншигч таньд хүргэе.

## Д.Эрдэнэбат: Хоёр хүний маргааныг төрийн танхимд оруулж ирлээ

-Өнөөдөр /өчигдөр/ Засгийн газрыг огцруулах асуудлыг эцэслэн шийдэх хуулийн хугацаа дуусна. Ямар ч байсан Засгийн газрын асуудлыг эцэслэн шийдэх ёстой гэж харж байлаа. Харамсалтай нь олонхийн бүлэг өөрсдийн дотоод асуудлаа төрийн танхимд оруулж ирлээ. Тусгай хяналтын дэд хороогоор Ерөнхий сайд болон Шадар сайдыг тагнаж чагнасан асуудлыг хэлэлцэх бололтой. Хоёр хүний маргааныг хэлэлцэж болохгүй. Энэ бол хууль бус. Яагаад гэвэл өнөөдрийн чуулганаар зөвхөн Засгийн газрыг огцрох эсэх асуудлыг хэлэлцэхээр оруулж ирсэн. Ээлжит бус чуулган зөвхөн байнгын хороогоор хэлэлцсэн асуудлаа л хэлэлцэх учиртай. МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа хийсэн мэдэгдэлдээ олонхийн бүлэг АН-тай хамтарч засаг унагах нь гэсэн туйлын хариуцлагагүй мэдэгдэл хийлээ. Би өмнө нь байр сууриа тодорхой илэрхийлсэн. МАН өнөөдөр 65 суудалтай. Үнэмлэхүй олонхийн



бүлэг Засгийн газраа хэрхэх нь бидэнд хамаагүй. Цөөнхийн бүлэг байр сууриа илэрхийлсэн. Засгийн газраа авч үлдэх үү, үгүй юу гэдэг нь тэдний дотоод асуудал. Үндсэн хуульд заасан хуулийн хугацаа буюу 15 хоногийн хугацаанд багтаж чуулганаа хуралдуулж чадахгүй бол УИХ-ын дарга Үндсэн хууль зөрчсөн асуудалд унана шүү гэдгийг эрх баригчдад дахин сануулъя.

## Д.Хаянхярваа: Би хууль зөрчөөгүй

-Бүлэг өчигдөр хоёр ч удаа хуралдах гэж цугласан. Огцруулах бичигт гарын үсэг зурсан гишүүд хуралд оролцохгүй ээ гээд ороогүй. Ер нь бол завсарлага авна гэдгийг бүлгээр шийдсэн. Засгийн газрыг огцруулах үндсэн гурван шалтгаан өөрөө бодитой мөн үү, биш үү гэдгийг гишүүд өөрсдөө тайлбарлах байх. Ер нь Засгийн газрыг огцруулах асуудал хурдасч, нийгмийн анхаарлыг татсан нь гарцаа байхгүй Шадар сайдыг тагнаж чагнасан гэх маргаанаас үүдэлтэй. Тиймээс энэ асуудлыг нэг талд нь гаргах ёстой. Нийгэмд тагнаж чагнасан гэх буруу ойлголт өгч байна. Төрийн тусгай албадад үүрэг өгсөн юм уу, эсвэл өөрсдөө тагнаж чагнасан юм уу гэдгийг ялгаж салгах ёстой. Улстөрчдийг хооронд нь хагаралдуулж байгаа учраас ялгаж салгах нь зөв гэж үзсэн хэрэг. Тиймээс Тусгай хяналтын дэд хороо заавал хэлэлцэх учиртай юм. Би хууль зөрчөөгүй. Бүлэг дээр Бага хурлаа чуулганаас өмнө хойно хуралдуулах уу үгүй юу гэдгийг хэлэлцэх байсан. Өчигдөр огцруулах гарын үсэг зурсан гишүүд хуралдаа ирээгүй. Тэр хурлаар шийдсэн. Хуулийн хугацаа маргааш /өнөөдөр/ дуусна. Тиймээс хэлэлцэж амжина.

## Тусгай хяналтын хороо ашиг сонирхлын зөрчил гаргав

Шадар сайдаа тагнасан гэх маргааныг чуулган түр завсарласан хугацаанд хэлэлцэх учиртай Тусгай хяналтын дэд хороо хуралдах шаардлагагүй гэсэн шийдвэрт хүрсэн юм. Тэд хэлэлцэх асуудлын жагсаалтад байхгүй учраас Шадар сайдаа тагнасан эсэхийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн аж. Гэвч энэ хороонд багтдаг гишүүдийн дийлэнх нь АН-ын болон Засгийн газраа огцруулахаар санал өгсөн олонхийн бүлгийн гишүүд байсан гэж хэлж болно. Тусгай хяналтын дэд хороонд УИХ-ын гишүүн Я.Санжмятав, Н.Энхболд, Д.Цогтбаатар, Г.Занданшатар,Сү. Батболд нар багтдаг. Гэтэл эдгээр таван гишүүн Засгийн газраа огцруулах сонирхолтой хэсэг бүлгийн эрх ашгийг дэмжиж буй учраас дэд хорооны хуралдааныг гацааж орхисон юм. 13.00 цагт завсарлага авсан учраас хуралдаан хуулийн хугацаанд буюу 16.00 цагт эргэж хуралдах ёстой байв. Гэсэн ч 19.00 цаг хүртэл хойшилж хэргийн материалтай танилцаж байна гэх шалтгаанаар бүтэн өдрийн хурлыг тавхан гишүүн хойш татаж, өнөөдөр хуралдахаас өөр аргагүйд хүрэв. Огцруулна, огцруулахгүй хэмээн хоёр талцсан олонхийн бүлгийн улстөрчид өчигдөр Төрийн ордонд муур хулгана болж тоглосоор нэг өдрийг өнгөрүүллээ. Хэлэлцэж буй асуудалтай холбоогүй асуудлаар завсарлага авсан, аваагүй гэх маргаан л өчигдрийн ярих сэдэв болж үлдсэн юм.

## МАН хоёр бүлэгтэй болсон уу

Чуулган орно, орохгүй, дэд хорооны хурал эхэлнэ, эхлэхгүй гэсэн хүлээлт үндсэндээ 20.00 цаг хүртэл үргэлжилсэн гэхэд болно. Энэ хугацаанд улстөрчид ч зүгээр суусангүй. Тухайлбал, УИХ-ын гишүүн Н.Номтойбаяр Шадар сайд өөрийг нь тагнаж чагнасан асуудалд намайг хамаатай гэх мэтээр бүлгийн хурал болон намынхаа гишүүдэд ярьсан учраас энэ асуудлыг шалгуулах хүсэлт гаргасан юм. Мөн л Тусгай хяналтын дэд хороонд хандсан ч хэн ч түүний хүсэлтэд хариу өгөөгүй. Олонхийн бүлгийн дотоод зодооныг хөндлөнгөөс ажиж суусан АН-ынхан хэдийгээр намын дотоод асуудал мөн боловч асуудлаа хуулийн хугацаанд хэлэлцэх ёстойг сануулж анхааруулга хүргүүлэхээ мартсангүй. Тодруулбал, хуульд заасан хугацаандаа асуудлаа хэлэлцэхгүй бол Үндсэн хуулийн зөрчил рүү явж байгааг УИХ-ын дарга М.Энхболдод анхааруулж, албан бичиг хүргүүллээ. Сэтгүүлчдийг чуулганы танхимын гадна чилээж орхисон улстөрчид энэ хугацаанд харин хоёр хуваагдан хуралдлаа. Тодруулбал, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваагийн өрөөнд огцруулах албан бичигт гарын үсэг зураагүй гишүүд хуралдсан бол, Шадар сайдын өрөөнд огцруулахаар шийдсэн 31 хуралдсан гэхэд болно. Үндсэндээ өнгөрсөн мягмар гарагаас эхлээд тэд бүлгийн хуралдаа ч суухгүйгээр Шадар сайдын өрөөнд байсхийгээд л хуралдаж байгаа бор шувуу саарал ордонд нисч байлаа. МАН-ын бүлгийн дарга хэвлэлийнхэнд ярилцлага өгөхдөө "Манай нөгөө бүлгийнхэн" хэмээн ярьж, 65 гишүүнтэй МАН-ын бүлэг хоёр хуваагдсан гэдгийг батлаж орхив.

Чуулганы хурадааныг өнөөдөр 10:00 цагт хуралдуулах тов гарчээ. Өнөөдөр эцсийн хугацаа юм.

Дугаарын 60 мөр

## Сонины үе дуусах болоогүй шүү

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Худлаа хэлээд, санаанаасаа зохиож, сошиалд ямар ч мэдээлэл цацсан шүүлтүүргүй болсон. Дээрээс нь сошиал хүрээнд байгаа хэдэн хүн аливаа мэдээллийг нягталж, шалгахгүйгээр тараах "дон" тусчихсан. Цуурхал яаж тардаг билээ, яг түүн шиг. Бүр улстөрчид нь хүртэл сошиалыг мэргэжлийн хэвлэлээс илүүд үзээд байгаа. 2016 оны сонгуулиар намууд өдөр тутмын сонинг дутуу үнэлж, сошиалд илүү их итгэсэн гэдэг. Тэр дундаа ялагдсан нам. Ямар сайндаа л ялагдах вэ дээ. Ерөнхийлөгчийн сонгуулиар ч гэсэн сошиалд илүү их ач холбогдол өгч оролцоод, унасан жишээ байж л байна. Гэтэл яг начир дээрээ иргэд сошиалын мэдээлэлд итгэдэггүй гэдгийг олон улсын судалгаа хүртэл харуулжээ. Өмнөд Солонгос, Германд судалгаа хийж үзэхэд сонинд илүү итгэдэг гэж иргэдийн олонх нь хариулсан байна билээ. Үндсэндээ цаасан хэвлэл, тэр дундаа өдөр тутмын сонины мэдээлэлд илүүтэй итгэдэг гэсэн үг. Харин сошиалын мэдээлэлд бараг итгэдэггүй гэдгээ илэрхийлсэн байна билээ. Манайд ч ялгаагүй. Иргэд сошиалд гэхээсээ илүү цаасан хэвлэл, тэр дундаа өдөр тутмын сонины мэдээлэлд илүүтэй итгэдэг гэж хариулж байна. Мэдээж телевиз бол мэдээлэл олж авах гол хэрэгсэл. Гэхдээ өдөр тутмын сонин гэдэг ямар ч мэдээллийн хэрэгслээс илүүтэй үнэ цэнэтэй гэдэг нь өдөр ирэх тутам мэдрэгдсээр байгаа юм. Сошиал яах вэ, хэсэгхэн зуурын үзэгдэл. Нэг хэсэг дэлхий нийтээрээ шуурсан. Одооноос сошиалаас дэлхий дахин татгалзах эхлэлээ тавьчихсан. Орон болгонд иймаян өрнөж эхэлсэн гэнэ лээ. Монголд ч ялгаагүй. Иргэд өдөр тутмын сонины мэдээлэлд илүүтэй итгэдэг. Сошиалын мэдээлэлд итгэдэггүй гэдгээ илэрхийлж байна. Ерөөс сошиалд эх сурвалжгүй, үнэн худал нь мэдэгдэхгүй мэдээлэл тардаг. Эргээд унших гэхээр устгачихсан байдаг хэмээн иргэд хэлж байх юм. Харин өдөр тутмын сонины мэдээлэл эх сурвалж сайтай, эргээд буух эзэнтэй, хаягтай, үнэн бодит байдаг гэдгийг ч хэлж байгаа юм. Энэ бүхэн өдөр тутмын сонины нэр хүнд, цар хүрээ хумигдаагүй шүү гэдгийг харуулж байгаа хэрэг. Ерөөс хумигдах ч үгүй. Яахав, өөрийн гэсэн редакцитай, мэргэжлийн сэтгүүлзүйн хэмжээнд ажилладаг сайтууд бол өөдөлнө, дээшилнэ, цар хүрээ нь томорно. Тэр тодорхой. Харин хэн дуртай нь үзэл бодлоо илэрхийлдэг, юу дуртайгаа бичдэг сошиал сүлжээ газар авахгүй нь тодорхой. Өдрөөс өдөрт л хүмүүс мэргэжлийн сэтгүүлзүй, үнэн бодит мэдээллийг ялгаж, салгаж чаддаг болж байна. Өдөр тутмын сонины ач холбогдлыг ч мэддэг, мэдэрдэг болж байгаа. Тиймээс л сонины үе дуусах болоогүй шүү. Дуусах ч үгүй гэж хэлэх гээд байна. Угаасаа сонины үе дуусахгүй. Энэ чинь сонгодог.


## ГАЗРЫН ТОС, УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР ГАДААДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛАХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОГЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Газрын тос, уул уурхайн чиглэлээр гадаадын их дээд сургуульд суралцах хүсэлтэй иргэдийг уралдаант шалгаруулалтанд оролцохыг урьж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Ашигт малтмал, газрын тосны газар хамтран уралдаант шалгаруулалтыг зохион байгуулж, гадаадын их дээд сургуульд бакалавр, магистрын чиглэлээр тэтгэлэгтэй суралцуулна.

Сонгон шалгаруулалтыг Засгийн Газрын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам"-ын дагуу зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр зохион байгуулна.

- **Бүртгэл:** 2017 оны 10 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд
- **Шалгаруулалт:** 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 10.00 цагт эхэлнэ.

**Иргэд бүртгүүлэхээр ирэхдээ доорхи бичиг баримтыг бүрдүүлж ирнэ:**

- о Газрын тосны салбарын болон суралцах чиглэл, мэргэжлийнхээ талаар англи хэл дээр өөрийн бичсэн 1500-2000 үгтэй эссэ
- о Газрын тос, уул уурхайн салбарын чиглэлийн мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж байгааг болон голч дүнг гэрчлэх сургуулийн тодорхойлолт /голч дүн 3.0-с дээш байх/,
- о Боловсролын гэрчилгээний хуулбар /Эх хувийг хуулбарын хамт/
- о Иргэний үнэмлэх /Эх хувийг хуулбарын хамт/
- о Сонгон шалгаруулалтанд орох хүсэлт /өргөдөл/
- о Оюутны үнэмлэх /Эх хувийг хуулбарын хамт/
- о Нэг хувь цээж зураг

Магистрт суралцах иргэд дээрхи баримт бичгүүд дээр нэмж:

- о Бакалаврын диплом /Уул уурхай, газрын тосны чиглэлийн мэргэжил эзэмшсэн/
- о Суралцахаар сонгосон улсынхаа сургалтын стандартыг хангах хэмжээнд гадаад хэлийг эзэмшсэнийг нотлох баримт бичиг
- о Нийгмийн даатгалын дэвтэр /сүүлийн 2 жил баталгаажсан байх/
- о Ажиллаж байгаа байгууллагын тодорхойлолт
- о Оршин суугаа газрын баг, хорооны засаг даргын тодорхойлолт

**Харилцах утас:** 263963,

**Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:** Legalinfo.mn, Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолын хавсралт журамтай танилцана уу.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

# ДЭЛХИЙ

# ФОРУМЫН ЭХНИЙ ӨДӨР 1.16 ТЭРБУМ РУБЛИЙН 11 ГЭРЭЭ ҮЗЭГЛЭЛЭЭ

Б.ДАВАА

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины санаачилгаар гурав дахь жилдээ зохион байгуулагдаж буй Дорнын эдийн засгийн чуулган өчигдөр тус улсын Владивосток хотноо эхэллээ. Чуулган хоёр өдрийн турш үргэлжлэх бөгөөд өнөөдөр өндөрлөх юм.

Дорнын эдийн засгийн чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ нарын төр, засгийн тэргүүнүүд, дэлхийн 15 орны 3000 гаруй бизнесийн төлөөлөгчид оролцож байгаа юм. Харин Монголын талаас Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг зэрэг албаны хүмүүс болон бизнесийн 70 гаруй төлөөлөгч оролцож байгаа ажээ.

Ерөнхийлөгч Х.Баттулга форумын хүрээнд зохион байгуулагдсан Монгол-Оросын бизнес уулзалтад оролцсон талаар ОХУ-ын хэвлэлүүд онцоллоо. Энэ үеэр тэрбээр “Миний бие бизнес эрхлэгчийн хувьд 1990 оны эдийн засгийн хүнд шилжилтийн үеэс ганзагын худалдаачнаас үйлдвэрийн захирал хүртэлх замыг туулахдаа Оросын бизнес эрхлэгчидтэй нягт хамтарч ажиллаж байсан юм. Өнгөрсөн хугацаанд УИХ-д гурван удаа сонгогдож, Засгийн газарт хоёр удаа сайдаар томилогдон ажилласан. Би Засгийн газрын гишүүнээр ажилласан хугацаандаа ХАА, дэд бүтцийн салбарт нэлээд анхаарч, судалгаа хийж ажилласан юм.

Монгол Улс Эрдэнэт үйлдвэрийг ОХУ-тай хамтарч байгуулж, Монголд зэс баяжуулах үйлдвэр барьсныг бид мэднэ. Энд судалгааг зөв хийж, боловсон хүчнийг цогцоор нь бэлтгэснээр одоо хүртэл Монгол Улсын эдийн засагт ашиг тусаа өгсөөр байгаа юм.

Үүнтэй адилханаар Монголын говьд, Дорноговь аймгийн төв Сайншандад Эрдэнэттэй тэнцэхүйц аж ахуй байгуулъя гэсэн ирмүүн хүслээр их хэмжээний судалгаа хийснээсээ бас танилцуулъя гэсэн бодолтой байна.Энэ юу вэ гэхээр уул уурхайн бүтээгдэхүүнээ бид түүхийгээр нь экспортолдог биш, тодорхой хэмжээгээр боловсруулдаг арвин туршлагаа Эрдэнэттэй зүйрлэн барьж байгуулъя гэсэн санаа дэвшүүлж байгаа” хэмээн ярьжээ.

1990 - 2016 онуудад Монгол Улсад нийт 18.9 тэрбум гаруй ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн бол үүний ердөө 2.15 хувь буюу 407 сая ам.долларыг ОХУ-аас хийгджээ. ОХУ Монгол Улсад хийгдсэн энэхүү хөрөнгө оруулалтынхаа дийлэнх буюу 45 орчим хувийг тээврийн салбарт, 36 хувийг нь уул уурхайн салбарт оруулсан байна.

Манай хоёр орны худалдааны нийт эргэлт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 559.32 сая ам.доллар бөгөөд үүнээс экспорт 27.13 сая ам.доллар, импорт 532.18 сая ам.доллар байна. ОХУ-ын тухайд Дорнын эдийн засгийн форумын эхний өдөр 1.16 их наяд рублийн 11 гэрээг үзэглэжээ. Энэ талаар “РИА новости”-д ОХУ-ын Шадар сайд Юрий Трутнев мэдээлсэн байна. Тэрбээр “Бид өнөөдөр 1.16 тэрбум рублийн 11 гэрээ, хэлэлцээрийг үзэглэнэ. Төсөл, хөтөлбөр бүр амжилттай хэрэгжихэд ОХУ-ын Засгийн газраас бүхий л хүчээ дайчлан ажиллана” гэжээ.



## Ерөнхийлөгч Японы Ерөнхий сайд Шинзо Абэтэй уулзлаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай чуулганы үеэр уулзахаар өмнө нь тохирсон билээ. Тодруулбал, Унгарын нийслэл Будапешт хотод зохион байгуулагдсан Жүдогийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр манай хоёр улсын төрийн тэргүүн уулзаж, Дорнын эдийн засгийн чуулганы үеэр илүү дэлгэрэнгүй яриа хэлэлцээр өрнүүлэхээр тохирсон юм. Тэгвэл Ерөнхийлөгч форумын эхний өдөр ОХУ-ын төрийн тэргүүнтэй уулзсангүй. Тэрбээр төрийн тэргүүний төвшний уулзалтаа гуравдагч хөрш гэгддэг Японоос эхэлжээ. Ерөнхийлөгч Х.Баттулга тус улсын Ерөнхий сайд Шинзо Абэтэй уулзсан аж. Уулзалтын үеэр Ш.Абэ “Х.Баттулга таныг Монгол Улсын ерөнхийлөгч болсонд туйлын баяртай байна.

Монгол Улсыг дипломат харилцааны чухал түнш гэж үзэж байна. Иймээс цаашид тантай дахин уулзаж хамтарч ажиллахдаа таатай байх болно” гэдгийгтодотгосонбайна.Үүний дараа БНСУ-ын төрийн тэргүүн Мүн Жэ Интэй уулзлаа. Харин өнөөдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай уулзаж, хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр санал солилцох аж. Энэ үеэр Транзит тээврийн гэрээнд гарын үсэг зурна гэх мэдээлэл байгаа ч, хараахан батлагдаагүй байгаа юм.

## ОХУ 1.2 их наяд рублийн 32 гэрээ, хэлэлцээр үзэглэхээр төлөвлөж байна

Өнгөрсөн жилийн хоёр дахь удаагийн Дорнын эдийн засгийн чуулган ОХУ-ын алс дорнодыг хөгжүүлэхэд чиглэж байсан билээ. Тэгвэл энэ жилийн чуулган зам тээвэр, мод бэлтгэл, алт алмаз олборлолт, загас агнуур гэх мэт эдийн засгийн тодорхой салбаруудыг хөгжүүлэхэд чиглэж байгаа аж.

Мөн өмнөд форумуудын нэгэн адил ОХУ-Энэтхэг, АСЕАН, БНХАУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудын хооронд ОХУ-ын алс дорнодын гадаадын хөрөнгө оруулалтыг сайжруулах таван төрлийн бизнес уулзалтыг зохион байгуулах юм байна.

Уулзалтаар хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, барилгын материал, хүний нөөц, ашигт малтмалын боловсруулалт, уул уурхай зэрэг хэд хэдэн хөрөнгө оруулалтын төслийг хэлэлцэхээр төлөвлөжээ.

Оросын алс хязгаарын тухайд жил бүр гадны хөрөнгө оруулагчдад таатай орчинг бүрдүүлэх механизмыг хөгжүүлж ирсэн байдаг. Зөвхөн сүүлийн гурван жилд гэхэд 2.2 их наяд рублийн хөрөнгө оруулалт татаж чадсан бөгөөд үүний 1.4 их наяд рублийг тухайн бүс нутгийг хөгжүүлэх 17 тэргүүлэх салбарын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна. Өнгөрсөн жилийн хувьд тус эдийн засгийн чуулганаар 1.85 их наяд рублийн 216 гэрээ хэлэлцээрийг үзэглэсэн байдаг. Харин энэ онд 1.2 их наяд рублийн 32 гэрээ хэлцэлийг оролцогч талуудад танилцуулахаар төлөвлөж байгаа аж.

## Урлаг соёлын үйл ажиллагаа ч багтаж байна

Алс Дорнодын эдийн засгийн чуулганы үеэр урлаг соёлын хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Чуулганд оролцож буй 3000 орчим төрийн тэргүүн бизнесийн салбарын төлөөллүүд Алс Дорнодын холбооны их сургуулийн боловсрол шинжлэх ухааны музей, Приморийн галлерей, “Приморский”-ын музей зэрэг байгууллагуудад болох үзэсгэлэнтэй танилцахын зэрэгцээ өөрсдөө оролцохоор болжээ.

Тус үзэсгэлэнд манай улсаас үндэсний үйлдвэрлэгч “Говь” ХК, АПУ ХК форумын үзэсгэлэнд оролцон бүтээгдэхүүнээ танилцуулж байна. Мөн чуулганы өдрүүдэд Санкт-Петербургийн театрын орон нутаг дахь салбар “Seaside Mariinsky” театрын урын сангаас үзэж сонирхох боломжтой юм. Үүнээс гадна ОХУ-ын хөгжмийн зохиолч Юрий Башмет “Soloists of Moscow” чуулгын уран бүтээлчдийн тоглолт, “Нойрсож буй гүнж” баллетыг тоглох ажээ.

Харин өнөөдөр Энэтхэгийн “Indian Ocean” жазз хамтлагийн шоу тоглолт болохоор төлөвлөгдсөн байна.

ЧӨЛӨӨТ СЭТГҮҮЛЧИЙН ИНДЭР

# УУЛ УУРХАЙН ХАЯЛГА



Говьсүмбэр аймаг Т.БОЛДБААТАР

Манай аймагт Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхайн ашиглалтын явцад шүүрүүлж юүлсэн гүний усны “Хаялга” нэртэй нуур тогтоод 20 гаруй жил болжээ. Анхандаа хэлний мэргэжлийн хүний хувьд энэ нэрэнд сүжиг муутай, баахан сэтгэл дундуур явах л даа. Байгалийн чандмань эрдэнэ, говь талын хээрийн бүсэд бялхаж цутгаад байдаггүй усыг шавхаж шавхчихаад “хаялга” байхдаа яахав. Үг, нэршил мундсан биш ухааны юм бодох. Өнөө харахнаа, арилжаа наймаанд нүнжиг буянтай загнах, бизнесийн салбарт өгөөмөр өгөөжтэй хандах нь байх л асуудал. “Хэр хаялгатай эр вэ дээ” гэж ярилцах нь бий. Үүнтэй жишихэд энэ нуурын хаялга нь адаглаад л хүнсний зориулалтаар ашиглах махны чиглэлийн цагаан сугас загас нутагшуулж овоо хэдэн тоо толгойд хүрсэн гэж байгаа. Хараахан бизнес нэвтрээгүй болохоор ашиг орлого, зарлага үрлэг тооцоогүй л байна.

Бидний хэсэг сэтгүүлчид говийн бүсэд сэлүүхэн амьсгалах сэрүүхэн салхины сураг ч үгүй байдаг зуны халуун өдрүүд дамнуулан Өмнөговь аймгийн Оюутолгой, Эрдэнэс таван толгой, Ухаа худгийн уурхайнуудад танилцах аялал хийсэн юм. Аялал жуулчлалын зориулалттай том оврын автобусаар пиг дүүрэн зорчиж яваад сэтгүүл зүйн богц дүүрэн багц, багц олз омогтой ирлээ. Нийслэлээс гарах замын эхэнд сониуч соргог гэж жигтэйхэн, хавь орчноо гярхай ажиглахнаа, оройтож орсон борооны хөөнги униар татсан усан цэнхэр уул, толгод, хэц, нуруу бие биеэ үүрсэн мэт хөндөлдөнө. Миний хувьд, дэлхий даяарыг тэжээн тэтгэж, улс гүрнүүдийн хөгжил дэвшлийн түүчээ, нүүр царай, өнгө төрх болж байгаа хэтэрхий дур зоргоор, чөлөөт нийгмийн өнгө аясаар тоос, ис тортогноосоо ч илүү нүүгэлтсэн хар хэл ам, атаа жөтөө, төсөв төслийн хөрөнгөнөөс зувчуулж завшигчдын шунал, сөрөг энергийг агуулж, дагуулж яваа томоохон уул уурхайнуудын зүгээс тухайн орон нутагтаа хэр зэрэг өгөөмөр, дулаан хандаж, нийгмийн хариуцлагаа ямар түвшинд ухамсарлаж, өгөөж нүнжигээ хуваарилж байгааг олж харахыг зорьсон юм. Зам гудаст явж гавиагүй, үзэж харсан зүйл маруухан мань мэтэд хүчит техник, хүнд механизмын зураг танилцуулга, хагас сайжруулсан замын хоёр талыг холбож тэгнэсэн самбарууд гудамжны эх адагт, агаарт хөндөлдөх нь уул уурхайн компаниудын ялгах онцлог ч юм шиг. Хариуцлагатай уул уурхайн тухай яриаг амдуулан нэгэн сөрөг хандлага ажиглагдсаныг дурдахаас аргагүйд туллаа. Уурхай түшиглэсэн суурин газар гэвэл нэгэнт байгуулагдсан уурхай руу нүүдэллэн ирж суурьшсан айл өрх, хүн амыг хэлэх жишээний. Уул уурхайгаасаа нийгмийн хариуцлага нэхэж, шаардаж болсон юм сумын төв, суурин газрууд эргэн тойрны хэдэн км-ийн зайд нүдэнд өртөх хог хаягдалгүй байж болмоор. Ямар л хөрөнгө хүч, төсөв мөнгө шаардаа аж. Ажилгүйдэлд өртсөн гэх өч төчнөөн хүн гэр, хоршоо хоёрын хооронд хөлхөж, гудамж талбайгаар сэлгүүцэж байгаа. Сумын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын бөөн хүчийг ончтой дайчлан, зохион байгуулвал байгаль эхийн унаган төрх, царайг дарсан тал, хэц, толгод, гуу жалга, сархиагаар нэг эрээлжлэх хогноосоо салж болмоор. Гагцхүү сум багийн удирдлагуудын санаачилгатай зохион байгуулалт , иргэдийн идэвхитэй оролцоог дөгөөж өгөх ажил огт байхгүйтэй холбоотой хэрэг.

Хамгийн эхэлж танилцсан төрийн байгууллага Өмнөговь аймгийн Ханбогд сумын ЗДТГ байлаа. Сумын ИТХ-ын дарга Ш.Эрдэнэжил, засаг дарга Б.Дэмбэрэлсамбуу нар биднийг хүлээн авч сум, орон нутгийнхаа талаар дэлгэрэнгүй танилцуулав. Хөдөөгийн сумдад ховорхон бараг байхгүй дээ, “Иргэдийн хөгжлийн төв”-ийн хоёр давхар тохилог орчин үеийн загвар дизайнтай оффист хийсэн мэдээлэлд 15,1 мянган кв/км газар нутагтай, 6385 хүн амтай, ХАА-н зургаан багтай, хоёр бөхт тэмээний тоогоор сүүлийн арван жилд улсдаа төдийгүй дэлхийд тэргүүлж яваа тухай, 1991 онд нээгдсэн дэлхийд хамгийн их нөөцтэй Оюутолгой орд газраас 45 км, Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төвөөс 290 км, хамгийн том говь Галбын гурван хийдийн нэг энергийн төв Дэмчигийн хийдээс 12 км-ийн зайтай орших, төсвийн орлогынхоо 35 хувийг аймагтаа төвлөрүүлдэг, далайн түвшинээс дээш 800-1200 метрийн өндөрт өргөгдсөн энэ суманд өдөрт нэг хүн шилжин ирж харин гурав хоногт нэг хүн буцаж байдаг тухай дурдаж байлаа. “Өнөөдөр 39 орчим хэмийн халуун байна хөрсөн дээрээ бол 70 шахаж байгаа” хэмээн хөлсөө ч сэвэх юмгүй хээв нэг суугаа сумын засаг дарга “Зургаан мянга гаруй хөдөлмөрийн насны иргэдээс 400 орчим ажилгүй хүн байгаа, сумын тэргүүлэх чиглэл нь мэдээж МАА тэгээд хил орчны аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарна ” гэж нэмж хэллээ. 11 ортой хувийн эмнэлэгтэй, 50 ортой эмнэлэг ашиглалтад авсан, дуудлагын хоёр, ойрын дуудлагын нэг авто машинтай, сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилгын ажил эхлүүлсэн, энэ нь Оюутолгойн олон ажилчдыг эрүүл хоол хүнсээр хангах түшиц газар. Тус сум барга, буриад хониноос амьдын жин дээгүүр татдаг нутгийн илүү нугаламт Завилууд омгийн хонио өсгөж байгаа. Завилууд гэдэг нь нэг багийнх нь нэр. Оюутолгойн ажилчид Ханбогдод суурьшиж амьдрах урьдчилсан бэлтгэлээ хангахын тулд 16,0 хүн амын хэрэглээ, ачаалал дав дээр даах 1,8 Мегаватт-ын дулаан эх үүсвэрийг шийдэхээр ярилцаад байгаа ажээ. Захдуу хязгаарын сумдад санахаас цаашгүй хангамж шүү дээ. Мод үржүүлгийн талбайдаа ус чийгтэй, хөвдөн хөрстэй, сэрүүн бүсэд ургадаг 13 хятад гацуур тарьсаны 10-нь ургажээ. Тарьсан модонд урамшуулал олгодог бас хэвлэлийн төлөөлөгчтэй сум ганцхан эднийх. Бараг нь монголын уран сайхны “Говийн зэрэглээ” кинон дээр гардаг баахан “Манайх”-тай утга адил санагдлаа. Уурхайтай холбоотой цоо шинэ ажил санааны нэг нь малчдын санал өргөдөл гомдлын гурван талт зөвлөлтэй юм байна. Манай аймгийн ШОНУ-д хэрэгжүүлэхэд ядах юмгүй дээ. Энэ суманд 300 гаран ААН үйл ажиллагаа явуулдаг нь төвийн айл өрхийн тодорхой хувьтай дүйх тоо юм биш үү. Оюутолгой сумаас 1100 гаруй хүн ажилладаг ч сумандаа төрсөнөөс цаашгүй огт ирж үзээгүй нэгэн байхад сумаасаа гарч үзээгүй нь ч байх. Сонин байгаа биз. Нийтийг хамарсан бэлчээрийн дундын усан хангамжийг сайжруулах талын яриа хэлцээ, судалгаа явж л байгаа. 1994 оноос хойш хүндрэл дагуулсан усны асуудлыг 200 м өрөмдөж байж нөөц тогтоогоод байгаа. Уурхайн лицензийн талбайд орсон арван айлыг нүүлгэн шилжүүлж заримд нь нөхөн олговор олгосон. Сумаас 60-аад км-т нефьтийн ордтой. “Хүний ид шидээс илүүтэй байгалийн ид шид бүрдсэн газар юм. Галав юүлэхэд энэ хавийнхаа хэдэн хүнийг авч үлдэх хайрхан байна” гэж Галба хайрханыг хараад аугаа Данзанравжаа хэлсэн гэдэг. Сумынхан Оюутолгой хоггүй байж болоод байхад манай сум яагаад болохгүй гэж гэсэн хөдөлгөөн өрнүүлсэн байна. “Дулаацаж чадахгүй галын оронд дах нөмрөөд суусан нь илүү дээр” ч гэх шиг, “Нөхрийн төлөө нөхөр зовсон юм. Нөхөөсний төлөө зүү утас зовсон юм” ч гэх шиг. Говь нутгийн удам дагасан хэлэмгий, бэлэн цэцтэй хүн бололтой сумын засаг дарга Бодьхүүгийн Дэмбэрэлсамбуу. Арга ч үгүй биз. Унаган нутгийн удирдах ажил нэлээд жил залгуулж яваа хүн болохоороо.

ХххАвсан бол эгүүлэн өгөх, өгсөн бол авах аль, аль нь амьдралын философи. Нийгмийн хариуцлага талаасаа ажлын байр нь Оюутолгойд нийгмийн төвлөрөл суурьшил нь Ханбогдод байдагтай уялдаж унаган Ханбогдын Б.Наранбаатар гэр бүлийн хамт Монголын XXI зууны эдийн засгийн гайхамшиг, дэлхийд тэргүүлэх зэс эрдэнийн орд “Оюутолгой” төсөлтэй хамтран зорчигч болон ачаа тээвэр, АА-н авто тээвэр, тусгай авто засвар, хүний нөөц болон гэрээт үйлчилгээ эрхэлдэг “Ханбогд хурд” компани байгуулж ажиллаад таван жилийн нүүр үзэж байна. Энэ хамт олон уяа сойлго нь таарч шивхэрсэн хүлэг монгол наадмыг өнгөлдөг шиг менежмент, маркетингаа шинэ шатанд гаргаж компанийхаа дүр төрхөд шинэчлэл хийснээс гадна бүтээгдэхүүн үйлчилгээ, техникийн нөхцөлөө сайжруулахад онцгой анхаарч ирсний дүнд “Оюутолгой САМР”-д үйлчлэх стандартыг хангаж ажиллаж байна. Баялгийн эзэн Ханбогдын ЗДТГ Оюутолгойн ашиглалтын лицензийн хугацаа дуусах 2033 он хүртэл /цаашид сунгагдах боломжтой/ орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдолтой хамтын ажиллагааны гэрээ 2015 оны 4-р сарын 22-ны өдөр байгуулжээ. Ер нь Өмнөговь аймагт 80 гаруй орд, 200 гаруй илрэл тогтоогдож, ашиглалтын 93, хайгуулын 155 лиценз хүчин төгөлдөр байгаагаас ашиглалт, олборолтын үйл ажиллагаа явуулж байгаа 14 ААН байдаг ажээ. Таван толгой, Оюутолгой хоёулаа монгол улсын стратегийн ач холбогдолтой ордод хамаарч сүүлийн жилүүдэд аймаг, сумдын нийгэм эдийн засгийн хөгжилд ихээхэн түлхэц болж байгааг хүн болгоны амнаас сонсож явлаа. Бидний ажилласан Ханбогд, Цогтцэций суманд Таван толгой ХК, Оюутолгой, Эрдэнэс таван толгой, Энержиресурс ХХК-иуд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Энэ ч утгаараа Өмнөговь аймаг нь орон нутгийн төсвөөс улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлж байгаа аймгуудаас бүсдээ нэгдүгээрт, улсдаа Улаанбаатар хотын дараа хоёрдугаарт жагсдаг болсон нь чухамдаа уул уурхайн хаялга юм. Сүүлийн гурван жилийн байдлаар Оюутолгой компаний шилдэг ханган нийлүүлэгчдийг шалгаруулах “Эрдэнийн говь ” ёслол, “Ажилтай иргэн орлоготой өрх” нээлттэй өдөрлөг, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” –гийн мэдээлэл, цахилгаан дамжуулах томоохон дэд бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх, “Галбын говь залуусын дуранд” гар зургийн уралдаан, оюутанд тэтгэлэг гардуулах ёслол, мэргэжил олгох хөтөлбөр, орон нутгийн худалдан авалтыг сайжруулах хамтарсан ажлын хэсэг ажиллуулах, хил, уул уурхайн бүсэд шилжин суурьшсан эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, “Зан заншил-Сургалт” төслийг санаачлах, “Зөгийн үүр-100”, “Англи хэлтэй Өмнөговь” дэд хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх гээд эдгээр нь бүгд нийгмийн хариуцлага. Сонсоход ч чихэнд чимэгтэй байлаа. Ханбогд, Цогтцэций сумын ард иргэдийг бишгүй азтайд нь хөөрхөн атаархал төрсөнөө нуух юун. Оюутолгой төслөөс сүүлийн 10 жилийн хугацаанд 600 гаруй сая төгрөгийн тэтгэлэг олгосон бол 2016 оны хагас жилийн байдлаар нийт ажиллах хүчний 95%-ийг монгол иргэд бүрдүүлж байгаагийн 22 гаруй хувийг Өмнговийн иргэд эзэлдэг дүн гарчээ. Бас нэгэн сонин гэвэл, ус чандмана эрдэнэ болсон, шавхуур худаг дээр дээл хувцсаа гандаан, царай зүсээ гундаан байж хэдэн малаа усалдаг говь газар гэхэд Ханбогд сум цэвэр усан хангамжийн цогцолбортой болсон нь бөөн завшаан. Ханбогд сумаас 160 орчим км алс Энержи ресурс, Эрдэнэс тавантогой компаниуд үйл ажиллагаа явуулдаг Цогтцэций рүү хөдөллөө. Яг л Улаанбаатарын авто замын түгжрэл. Гэхдээ ирснийг бодвол арай сийрүү. Ачаагаа буулгасан том оврын машинууд хөл хөнгөн урагшлах ажээ. Зам гэж там болсон халж улайстал нь ээлж сэлгээгүй хүнд даацын машин цувах болохоор газрын хөрсийг онги нидэрч эвэрхий болсон, засаж янзалсан нь яр шарханд наасан цаасан лент мэт алаглаж харагдах, домносон төдий. Их шанхын хэцийн алдарт хурдан хүлгүүдийн цомбон туурайн тоос сураг алдарсан ч юм шиг. Миний Боржигины 14-16 чий /нэг чий 0,32 см/-ний углуургадаж угсардаг модон байшингийн дайтай нүсэр, нүсэр төмөр хөлгүүд хангир, жингэр зөрөөд л хичнээн ч км зам туулж нуруугаа хөнгөлж, хичнээн ч км-ийн урт дугаарлаж зогсдог юм бэ. Амь нас хамгаалах зургаан дүрэм. Айдас хүйдэст автаж, бие баглагдаж, хүлэгдмээр. Чалкогийн өрийг дарах замын гудаст хичнээн машин тэрэг саатаж, хөмөрч хөрвөөж, хэдэн эрдэнэт хүний халуун амь нас, зах хязгааргүй хүсэл мөрөөдөл сүйддэгийг хэн мэдлээ, ёстой бурхан л мэдэх биз. Миний хэрэгтэй хувцас, эдлэл, аягатай хоолыг минь авчих юм шиг хармын сэтгэл төрж байсныг яана гээ. Энержи ресурс ХХК-ний Ухаахудагийн уурхайн нэгдсэн сүлжээний цахилгаан хангамжийн ерөнхий схем-М-Си-Эс интернейшнл ХХК-ний Ухаахудаг салбарын захирал н.Хүдэрхуяг ажлаа танилцуулах талаараа гаргуун залуу санагдсан. Тус уурхай нь 2005 онд байгуулагдаж үйл ажиллагаа нь 2009 онд эхэлсэн мөн ондоо олон улсын хөдөлмөрийн зах зээлд гарсан юм билээ. Цогтцэций сумын төвийн хуучин төрхийг өвлөн үлдсэн эх оронч эмэгтэй баатар Түвдэнгийн Борын хөшөөг нэлээн эрж байж олж харсан гээд боддоо. 640 хүүхдийн сургалтын, 100 хүүхдийн дотуур байр, 110 хүүхдийн цэцэрлэгтэй “Мөрөөдөл” цогцолбороор орлоо. Улсдаа анхдагч бүтээн байгуулалт энэ цогцолборынхон гурван багштай дотуур байраа “Хүүхэд хөгжлийн төв” гэж үздэгээ шинэхэн захирал Б.Ганжаргал онцолсон. Говийн ирээдүйг “Мөрөөдөл”-ийн бүтээгдэхүүн цогцлоох алсын хараатай. Мөн сумын нүд хужирлах юмны нэг бол компанийн хөрөнгө оруулалтаар 2011 онд ашиглалтад орсон “Цэций” орон сууны хороолол. 600 өрх амьдрах, 11 блокоос бүрддэг хамгийн бага талбайтай нь 22м/кв бол том нь 59м/кв. Гурваас найман жилийн хугацаанд ажиллавал хувийн эзэмшлийнх болох нөхцөлтэй. Нэг давхарт нь нийтийн ахуй, худалдаа, хүүхэд харах үйлчилгээний салбарууд ажиллуулахад эхний жилдээ түрээсээс чөлөөлж бичил бизнес эрхлэлтийг дэмжих зорилготой. Уурхайн оффис гэхэд л газар дор нэг дээшээ гурван давхарт байрладаг. Сургалтын семулятор төхөөрөмжтэй, хүнд машин механизмын засварын төв, орчин үеийн лабораторитай, 2010 онд баригдсан галерей кемп нь 650 хүний багтаамжтай, 280 гаруй өрөөтэй, 250 хүнд зэрэг үйлчлэх цайны газар, эмнэлэг, номын сан, үсчин, дэлгүүр, спортын цогцолбороос бүрдсэн хачин тохилог буудал л гэсэн үг. Эдний хөрөнгө оруулалтаар 250 оюутантай МСҮТ-тэй болсон, баклаврын зэрэглэлтэй сертификаттай төгсөлт хийдэг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, гадаадад ажиллах эрхтэй коллежийн сургалтын стандартаар хичээллэдэг. Мэдлэг, ур чадвар, технологи дээшлүүлэхээр зохион байгуулдаг сургалтаа 3D гэцгээх. Учир нь Дархан, Дорнод, Даланзадгадын коллежиудтай хамтарч ажилладагтаа тэр. Ханбогд суманд ТМС-д дадлагаар суралцагчийн өмнөх төв байгуулсан. 220 гаруй төгсөгчдийн дийлэнх нь далд уурхайн бүтээн байгуулалтад оролцож байгаа. Энэ оны 4-р сад төгссөн гагнуурын 30 гаруй оюутнууд нь гүн уурхай, бусад ажлын хэсэглэлийн шаардлага захиалгаар бүгд ажлын байранд шилжсэн.

Газрын хэвлийн баялаг гэж гавих юм байгаагүй бол уул уурхайн үйлдвэрлэл хөгжихгүй, уул уурхай байгаагүй бол бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, нийгмийн асуудлууд шийдэгдэхгүй бахь байдгаараа үхэр харганы жимсхэн, цагаан, улаан гоёогоороо гайхуулсан шигээ халуу төөнөсөн бүгчим говь нутгийн уламжлалт аж ахуй, амьдрал хэвийн л үргэлжлэх байсан биш үү. Эрдэс баялгаасаа хувь хүртэж өнгөлөн өөдлөх амьдралтай яваа говь нутгийнхандаа баярлах нь зүйтэй. Хөл хөс дарсан газарт сайн сайхны зэрэгцээ саар муу, бүтэж явах нэг байхад бүтэл нь хазайсан үйл хэрэг алийг тэр гэхэв. Ерөөсөө сайнтай, муутай хорвоо дүүрдэг хойно. Сайн сайхан нь, үнэн цагаан, давуу тал нь л дийлэнх байвал болох нь тэр. Улс орноор үл барам даян дэлхийд данстай энэ их уурхайнуудын хаялга арвижан тэлж, уурхай түшиглэсэн орон нутгийн өнгө жавхаа өөдрөг өнгөлөг, хүн ардынх нь амьдрал дэгжин дээшлэх болтугай.

# МЭДЭЭЛЭЛ

Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ



## Б.Тэнүүнболд Өсвөрийн шатарчдын ДАШТ-ээс хүрэл медаль хүртлээ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэмжлэгийг амжилтаар хариулж байгаа тамирчдын буухиаг “Алаг морьт”, “Гоби чесс” клубын бяцхан тамирчин Баттулгын Тэнүүнболд үргэлжлүүллээ. Тэрбээр Бразил улсад зохион байгуулагдсан Өсвөрийн шатарчдын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эх орноо төлөөлөн оролцож хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлж, Дэлхийн шатрын холбооны дэд мастер буюу кандитат цолны болзлыг хангасан байна. Б.Тэнүүнболд эдүгээ гуравдугаар ангийн сурагч юм.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

## 4D хэт авиан оношилгооны шинэ аппараттай болжээ

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлж, хүртээмжийг сайжруулахаар тусгасан байдаг. Энэ дагуу орчин үеийн 4D эхо аппаратыг орон нутгийн төсвийн 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авч иргэддээ дөрвөн төрлийн үйлчилгээг үзүүлж эхэллээ. Эрүүл мэндийн хоёрдугаар төвд тус аппарат байрлаж байгаа бөгөөд ажлын өдрүүдэд найман цагаар ажиллаж өдөрт 40 орчим иргэнд үзлэг оношилгоо хийх ажээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

## 46 оюутанд нийт сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэв

Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” /2016-2020/ үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Боловсрол, соёл, урлагийн салбарт хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх, урамшлын тогтолцоог бий болгон тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тусгагдсан.

Тус зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын санаачилгаар “Дорноговь Их Хөгжил Сан” ТББ-ын санхүүжилтээр Дорноговь аймгаас Их, Дээд сургуульд элсэн суралцаж буй 46 оюутанд (тус бүр 500 мянга) нийт 23 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэв.

Сургалтын төлбөрийн батламж гардуулах арга хэмжээнд аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, аймгийн ИТХ-ын тэргүүлэгч, “Дорноговь Их Хөгжил Сан” ТББ-ын ТУЗ-ын дарга О.Батжаргал, Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлийн тэргүүлэгч, “Дорноговь Их Хөгжил Сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Бүрэндэлгэр нар оролцов.

Энэхүү хөтөлбөрийг цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулах талаар хэлэлцсэн бөгөөд тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын хичээлийн шинэ жилд амжилт хүсч баяр хүргэлээ.

ОРХОН АЙМАГ

## Ургац хураалт эхэлжээ



Орхон аймгийн хэмжээнд энэ жил 5062.2 га талбайд 21 аж ахуйн нэгж, байгууллага, 600 гаруй айл, өрх газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байна. Үүний 908.6 га нь усалгаатай талбай байдаг бөгөөд инженерийн хийц бүхий усалгаатай 446 га, гадаргын усалгаатай 462.6 га байдаг. Харин 4153.3 га талбай нь усалгаагүй аж.

Тус аймаг хаврын тариалалтын үед 4658 га-д тариалалт хийхээр төлөвлөн 5280.1 га талбайд тариалалт хийгдэж, тариалалтыг 113.4 хувьтай гүйцэтгэжээ. Энэ нь төлөвлөж байснаасаа илүү тариалалт хийсэн гэсэн үг юм. Үүнээс улаанбуудай 3840 га-д тарихаас 4300 га-д, төмс 380 га-д тарихаас 467.1 га-д, хүнсний ногоо 348 га-д тарихаас 285.55 га-д, тэжээлийн ургамал 90 га-д тарихаас 122.2 га-д, тосны ургамал 60 га-д тус, тус тариалалт хийсэн бөгөөд төлөвлөгөөт зорилт үр тариа 112.9 хувь, төмс 122.9 хувь, хүнсний ногоо 82.1 хувь, тэжээлийн ургамал 135.8 га-д тариалжээ. Урьдчилсан байдлаар нэгж талбайгаас улаан буудай 15.9 цн, төмс 70 цн, тэжээлийн ургамал 11 цн, хүнсний ногоо 60 цн хураах төлөвтэй байгаа бөгөөд үүнээс харахад энэ намар улаанбуудай 5943 тн, төмс 3336 тн, тэжээл 154 тн, хүнсний ногоо 1720 тонныг хураан авах боломжтой аж.

Одоогийн байдлаар үр тариа 450 га талбайгаас 600 тн буюу га-аас 13.3 цн, эрт ургацын ногооны түүвэр хураалт эхэлж төмс 231.5 тн, хүнсний ногоо 121.2 тн-ыг тус тус хураан авчээ. Харин ирэх жилийн тариалалтад зориулж 13 аж ахуйн нэгж дөрвөн иргэн 4241 га талбайд уриншийн боловсруулалтыг механик болон химийн аргаар гүйцэтгэсэн байна. Одоо хүнсний ногоо хадгалах зоорь, үтрэм, агуулахын цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээг хийж байгаа юм байна.

ЭРГЭН ДУРСАХУЙ



# ШОНХОРЫН ЗОРИГ МОХОХГҮЙ

1935-1937 оны үед манай улсын зүүн хил хязгаарын байдал түгшүүртэй байсантай зэрэгцэн Монголд өрнөсөн улс төрийн их хэлмэгдүүлэлт дээд цэгтээ хүрч, Монголын нийгмийн бүхий л давхаргыг хамарч сор болсон олон мянган гайхамшигт сэхээтнүүд, салбар салбарын анхдагчидыг “Японы тагнуул”, “Хувьсгалын эсэргүү” хэмээн хилс хэрэгт гүтгэгдэж баривчлагдан шийтгүүлж, олонхи нь цаазаар аван хэлмэгдүүлж байсан нь Монголын нийт насанд хүрсэн эрчүүдийн 15 хувийг хамруулсан туйлын эмгэнэлт түүх юм.

Улс төрийн хэлмэгдүүлэлт Монгол Ардын Хувьсгалт Цэрэг /МАХЦ/-ийн дотор Монголын нисэх хүчний нийт бүрэлдэхүүн, боловсон хүчинд айхтар цохилт өгч ЗХУ-д болон дотооддоо олон жилийн турш өндөр үнээр бэлтгэгдсэн, дайн байлдааны туршлагатай, нислэгийн ур чадварыг гоц эзэмшсэн олон арван нисгэгч, техникч, албан хаагчид, авьяаслаг дарга нарыг олноор хэлмэгдүүлсэн байна.

Нисэх хүчний анги салбараас 115 хүн хэлмэгдүүлэлтэн өртөснөөс 47 хүнийг баривчлан эдгээрээс өндөр албан тушаал хашиж байсан 25 хүнийг буудан хороож янз бүрийн шалтгаанаар 71 хүнийг ажлаас нь халсан байна. Эдгээрийн дотор анхны нисгэгч, хурандаа Д.Жамбаа, Ч.Шагдарсүрэн, Д.Дэмбэрэл, нисэх бригадын анхны комиссар Д.Бадамхатан /маршал Г.Дэмидийн садан/, Улаан тугийн одонт нисгэгч Р.Самдан, нисэхийн анхны техникчдийн нэг Л.Дамдин, анхны хянагчдын нэг П.Цэдэв зэрэг алдар цуутай хүмүүс, нисэх отрядын дарга Ч.Санжжав, С.Гомбо, нисэх сургуулийн захирал Б.Чоймбол, эскадрилийн дарга Ж.Дашдаваа, хэсгийн дарга Т.Төмөр, нисэх эскадрилийн байлдааны ангийн дарга Г.Дорж, зэвсэглэл албаны дарга Ц.Буджав, нисгэгч Т.Дамбий, Д.Жамц, Д.Жүгдэр, техникч Д.Мэнд, Б.Сэнгэдоо нарын зэрэг гэм зэмгүй удирдах болон дунд тушаалын дарга нар, нисгэгч, нисэхийн техникийн ажилтнууд хэлмэгдэн хохирчээ.

Монгол Ардын Хувьсгалт Цэрэг /МАХЦ/-ийн Нисэх бригадын байлдааны Нэгдүгээр отрядын дарга, шуудангийн отрядын дарга, анхны нисгэгч, Хурандаа Д.Жамбааг БНМАУ-ын ДЯЯ-ны сайд, Улсын өрлөг жанжин Х.Чойбалсангийн 1927(37) оны наймдугаар сарын 10-ны өдөр баталсан “Дайчлан баривчлах тогтоол”-оор тус яамны Улсыг аюулаас сахиж хамгаалах хэргийг удирдах ерөнхий газрын Тусгай хэлтсийн төлөөлөгч, хамгаалагч Дашзэвэг, Насантогтох нар Японы тагнуул, хувьсгалын эсэргүү хилс хэрэгт холбогдуулан дайчлан баривчлах санал төлөвлөн наймдугаар сарын 10-ны үүрийн 04 цагт гэртээ амарч байхад нь ирж баривчилж, харгис хатуу эрүү шүүлт тулган тамлаж, зохиомол хэрэг гүтгэн тулгаж, олон хоногоор гянданд тарчлаан зовоосны эцэст 1937 оны аравдугаар сарын 25-нд шүүх цаазын бичгийн 43, 44 зүйлээр хөрөнгийг нь хураах, цаазаар авах ялаар шийтгэжээ.

Тэрбээр МАХЦ-ийн Нисэх бригадын байлдааны нэгдүгээр отрядын дарга, Жанжин штабын шуудангийн тусгай отрядын дарга хүртэл өндөр албан тушаал хашиж, жирийн цэргээс анхны нисгэгч хурандаа цол хүртсэн манай нисэх хүчний ууган дарга нарын нэг байлаа.

Д.Жамбаа онгоцны моторчноос эхлээд байлдааны онгоцны нисгэгч, байлдааны нисэх отрядын даргаар ажиллаж, хурандаа цол хүртэж, харийн дайснаас эх орноо хамгаалах байлдаанд эрэлхэг гавьяа байгуулан байлдааны гавьяаны одонгоор хоёр ч удаа шагнуулж байсан нь Улсын баатар Д.Дэмбэрэл, Ч.Шагдарсүрэн нартай эн зэрэгцэх алдарт нисгэгч байжээ. Тэрээр Ю-13, Ю-33, К-5, Ган-3, Р-1, Р-5, И-3, У-1, У-2 зэрэг тэр үеийн агаарын бүх хөлгийг жолоодон нисэж, морь шигээ унаж эдлэн, чадмаг жолоодож, олон залууг сургасан анхны багш-нисгэгч, Жанжин штабын агаарын шуудангийн тусгай отрядын даргаар ажиллаж байсан Монголын нисэх хүчний анхдагчдын нэг жинхэнэ агаарын зоригт шонхор байлаа.

1925 оны сүүлчээс эхлэн нисэх онгоцны ангид Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн /МХЗЭ/-ийн илгээлтээр шилдэг залуучуудыг сонгож ирүүлсэн байна. Хамгийн түрүүнд А.Содном (хожим нь Цэргийн ерөнхий сургуулийн захирал болсон), Завхан аймгийн хамгаалахын Гүржав, цэрэг Содном, Бүргэд, Нацагдорж, Гэндэнжав, дараа нь Цэргийн дэргэдэх “Жавхланг бадруулагч” үүрээс эвлэлийн гишүүн Д.Лхамжав, Н.Сандуйжав, Х.Шарав, Д.Гэлэгравжаа, бусад үүрээс Ч.Шагдарсүрэн, Б.Батцэрэн, Д.Жамбаа нар иржээ. Тэд Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг дагалдаж нисэх онгоцны моторчин, төмрийн дархны мэргэжил эзэмшсэн байна. Эдний дотроос сурлага сахилга, идэвх сонирхол, авьяас чадвараараа шалгарсан Д.Жамбаа, Ч.Шагдарсүрэн, Б.Батцэрэн нар Зөвлөлтийн мэргэжилтэн Лозик, А.А.Лапин нарыг хоёр жил шахам дагалдан сургуулилж, байлдааны “Р-1” онгоцны нисгэгчид болсон байна

Ч.Шагдарсүрэн, Д.Жамбаа нар 1930 оны тавдугаар сард уг онгоцоор Улаанбаатар-Өндөрхаан-Баянтүмэн-Тамсагбулаг-Улаанбаатар чиглэлд нисч хоёр талдаа 2000 гаруй км урт агаарын замыг анх нээж аялан ниссэн нь ард олонд нисэх онгоцыг сонирхуулан сурталчлахын хамт улс орныг батлан хамгаалах хэтийн зорилготой байлаа.

Тэдний энэхүү гавьяа зүтгэлийг өндөр үнэлж, Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

Тэд мөн “Ю-13” онгоцоор алс холын замд чадамгай аялан, Монгол орныхоо нутаг дэвсгэр дээрх агаарын шинэ шинэ замыг нээсэн түүхтэй.

1930-аард оны эхээр Япон улсаас Алс Дорнодод явуулж буй түрэмгий үйл ажиллагаа нь улам идэвхжиж 1932 оны 3 дугаар сард Манжуур, Хятадын зүүн хойд нутгийг эзлэн авч “Манж-Го” гэх тоглоомын улсыг байгуулж, түүний нутгийг ЗХУ, Монголын эсрэг байлдааны талбар болгохоор бэлтгэсэн юм.

Япон, Манжийн тал 1934 оны дунд үеэс эхлэн Монгол улсын дорнод хил дээр удаа дараа өдөөн хатгалга үйлдэж хилийн зөрчил гаргаж эхэлсэн байна. Монгол Улсын эсрэг Япон, Манжийн цэргийн өдөөн хатгалга 1936 оны гуравдугаар сар гарсаар улам өргөжив. 1936 оны гуравдугаар сарын 29-ний өдрийн 11.00 цагийн үед Япон, Манжийн талаас найман машинтай 200 гаруй цэрэг манай улсын дархан хилийг нэвтрэн “Адаг дулаан”-ы харуул руу довтолсон мэдээ иржээ. Энэ үед зүүн хязгаарт өөрийн биеэр хүрэлцэн очоод байсан “Бүх цэргийн жанжин” Г.Дэмидийн тушаалаар нисгэгч Д.Дэмбэрэл, Д.Жамбаа нар 13 цаг 10 минутад тус бүр 20 ширхэг бөмбөг, 2400 ширхэг сум бүхий “Р-5” онгоцоо жолоодон “Тамсаг булаг”-аас нисч халдан довтлогчдын эсрэг эрэлхэгээр тулалдсан байна. Япон, Манжийн талаас дөрвөн машин эвдэрч, 100 шахам хүн алагдаж шархадсан ажээ.

Энэ өдрийн байлдаанд Д.Жамбаагийн онгоц дайсны суманд 30 удаа, Д.Дэмбэрэлийн онгоц 29 удаа тус тус оногдсоноос өөр хохирол гарсангүй бөгөөд ямар их ширүүн тулалдаан болсныг илтгэж байв. Япон, Манжийн цэрэгт цохилт өгч эрэлхэг гавьяа байгуулсан нисгэгч Д.Жамбаа, Д.Дэмбэрэл нарыг БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1936 оны 11 дүгээр тогтоолоор “Байлдааны гавьяаны II зэргийн” одонгоор хөхиүлэн шагнажээ.

“Буландэрс”-ний харуулаас 3 дугаар сарын 31-ний өглөөний 06 цагийн орчим “Улаантолгой” хавиас баруун урагш “Адагдулаан”-ыг чиглэн Япон, Манжийн цэргийн 2 хэсэг авто машины цуваа хөдөлсөн тухай мэдээ ирэв. Тэр нь 90 шахам машин 1000 гаруй цэрэг, 12 танк, их буу, долоон нисэх онгоцоор дэмжүүлсэн урьдынхаас том хүч байв. Мөн “Адагдулаан”, “Ар шаврын харуул”-аас дайсны ихээхэн хүч ирж буй тухай мэдээ ирж эхэлжээ.

Дайсны цуваа “Адагдулаан”-ы харуулыг чиглэн хөдөлсөн тухай мэдээг хүлээн авсан Бүх цэргийн жанжин Г.Дэмид түүнийг тосч байлдах шийдвэр гаргаж, 6 дугаар морьт дивизд, нисэх онгоцны нэгдсэн отряд, Матадад байрлаж байсан моторжуулсан отрядын дарга нарт зохих тушаал өгөв. Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн тушаал ёсоор А.В.Судец, Д.Жамбаа нарын жолоодсон “Р-5” онгоц Тамсаг булагаас хөөрөв. Д.Дэмбэрэлийн онгоцыг тагнах, холбоо барих үүрэгтэйгээр үлдээжээ. Япон, Манжийн тал дөрвөн онгоцоор Адаг дулааны харуулыг бөмбөгдөж, улмаар эзлэн авсан байжээ. А.В.Судец, Д.Жамбаа нар замдаа 1000 метрийн өндрөөс дайсны хүчийг тагнавал “Адаг дулаан”-ы харуулын дэргэдэх өндөрлөгийн бэлд 60-70 машин байв. “Тамсагбулаг”-аас ниссэн В.А.Судец, Д.Жамбаа нарын 2 ширхэг Р-5 онгоц цаг хагасын дараа “Баянтүмэн” ниссэн эскадрилийг тосон авч нийлэн “Адагдулаан”-ыг чиглэн нисжээ.

Нисэх бригадын сургагч В.А.Судец дайсны хүчийг тагнаж үзээд 1200 метр өндрөөс бүх онгоцны хүчээр бөмбөгдөж, дараа нь пулемётын галаар шумбан дайрах шийдвэр гаргаж 9 удаагийн дайралтыг амжилттай хийсний үр дүнд дайсанд багагүй хохирол учруулжээ.

Манай нисэх онгоцнуудын нэлээд нь буудлагын зэвсгийн галд өртсөнөөс гэмтэл авч байлдаанаас гарсан байна. Энэ агаарын дайралтад нэгдсэн отрядын дарга Ч.Шагдарсүрэн, хянагч Өлзийбат, Филь, Новосильцев нар шархаджээ. Дайсны бүлэглэл манай нисэх онгоцны дайралтад өртөж багагүй хохирол үзсэн бөгөөд байлдааны журам нь алдагдаж эмх замбараагүй тарж бутарсан байна. Энэ байлдаанд дайсны хүчийг бут цохиж ухраахад манай нисэх онгоцууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Монгол, Зөвлөлтийн нисгэгчид эрэлхэгээр байлдсан юм.

Нисэх онгоцны дайралт төгссөний дараахан нь байлдаан болж буй газарт “Тамсагбулаг”-аас хөдөлсөн маневрийн групп ирж дайралтад оров.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн 1936 оны дөрөвдүгээр сарын 7-ны өдрийн 17 дугаар хурлын тогтоолоор “дайсан этгээдэд туйлын хатуу цохилтыг өгч цаг тухай дор няцаан устгаж чадсаны дээр өөрийн улсын тусгаар тогтносон байдал ба эрх чөлөөт үндсэн газар нутгаа хатуу чийргээр хамгаалж Монгол Улсын эртний үеийн эрэлхэг түүхт байлдааны их сүр хөгжлийг дайсны өмнө ил тодорхойгоор үзүүлж чадсан” учир хоёрдугаар морьт корпусын агаарын отрядын штабын дарга нисгэгч Д.Дэмбэрэлд “БНМАУ-ын агаарын зоригт баатар” цол олгож, нисэх хүчний нэгдсэн отрядын дарга Ч.Шагдарсүрэнд “Улсын эрхэм нисгэгч” цол олгож, Улаан тугийн гуравдугаар зэргийн, нисэх бригадын сургагч В.А.Судецийг хоёрдугаар зэргийн одонгоор шагнажээ. Монголын Ардын Хувьсгалт Цэргийн Нисэх хүчин оролцсон 1936 оны байлдаан нь манай нисэх хүчний түүхэнд анхны томоохон агаарын тулалдаан болсон ба нисэх хүчин сургалт бэлтгэл, байлдах чадвараа ямар төвшинд байгааг мэдэх, харьцуулж үзэх том шалгалт болсон байна.

Д.Жамбаа нь ДЯЯ-ны Тусгай хэлтсийн цэргийн тасгийн дарга, байцаагч Мандал, Лувсандоной нарт өгсөн мэдүүлэгтээ “би 1906 онд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн. Асгатын хүрээнд мяндаг тушаалгүй лам байсан, 1925 онд сайн дураар хар болж цэрэгт ирсэн. 1926 оны хоёрдугаар сараас тавдугаар сарын 20 хүртэл хотод оюутны сургуульд явж байсан. 1926 оны тавдугаар сард нисэх онгоцны техникчийн сургууль, 1930-1933 онд ЗХУ-ын Оренбург хотын нисэх онгоцны жолоочийн сургууль хийж төгссөн. 1937 оны наймдугаар сар хүртэл байлдааны нисэх отрядын дарга, баригдахын өмнө цэргийн нисэх онгоцны шуудангийн отрядын даргаар ажиллаж байсан, МАХН-ын гишүүн, хурандаа цолтой, ам бүл 6, хувь хөрөнгө 70, Сайн ажилласан учир байлдааны буу 3 ширхэг, мөнгөн хайрцаг, цаг тус тус нэгээр шагнуулж байсан, Ардын хувьсгалын 15 жилийн ойгоор Улаан тугийн одонгоор, 1936 онд Япон, Манж лугаа баатарлаг байлдсаны учир Улаан тугийн 2-р зэргийн одонгоор шагнагдаж байсан”, “Жамбаа миний биед хувьсгалын эсэргүү санаа бодлогыг агуулж, Хувьсгалын эсэргүү байгууллагад оролцож, хувьсгалын эсэргүү ажлыг хийж явсан удаагүй бөгөөд харин манай нисэх онгоцны бригад болоод отрядуудад хувьсгалын эсэргүү, хорлон сүтгэгч этгээд нар байсныг би мэдэх бөгөөд “тэд нарыг яахан илрүүлж эсэргүүцэн тэмцэх билээ” хэмээн бодож ажиллаж явснаас өөр тийм хувьсгалын эсэргүү ажлыг хийж яваагүй амой” ... гэжээ.

Хожим 1991 онд Улсын дээд шүүхийн Цагаатгах комиссын 108 дугаар магадлангаар түүний гэм буруугүйг нотолж цагаатгажээ.

1965 онд Нисэх хүчний 40 жилийн ойгоор 1964 онд Нисэх хүчний 40 жилийн ойгоор ЗХУ-аас хүндэт зочдыг урихад Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ), Монгол Улсын баатар, нисэх хүчний маршал В.А.Судец ирж Д.Жамбаад Монгол Улсын баатар цолыг нь нэхэн олгох саналыг Ю.Цэдэнбал даргад тавьж тэрээр дэмжсэн боловч төрөлх сумынх нь дарга хөдөлж өгөлгүй хоцроосон” хэмээн дурссан байдаг.

Үнэхээр 1964 онд Д.Жамбаад “Улсын баатар цол” нэхэн олгох санал санаачилга гаргасан ч зарим нэг урагшгүй хүний хар гайгаар бүтэлгүйтэж, улмаар мартагдахад хүрчээ..

Монгол Улсад Нисэх хүчин үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг тохиолдуулан ИНЕГ-аас алдарт нисгэгч, зоригт шонхор, ахмад үеийн анхны нисгэгч, хурандаа Д.Жамбаа агсны намтар түүхийг сэргээн мөнхжүүлж, түүнд Монгол Улсын баатар цолыг нэхэн шагнуулах санаачлага гаргасныг Зам, тээврийн хөгжлийн яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, УИХ-ын Гадаад бодлого аюулгүй байдлын байнгын хороо дэмжсэн тодорхойлолтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газарт хүргүүлсэн байна.

Хорь дугаар зууны эхний хагаст дэлхийн том гүрнүүдийн бодлого, ашиг сонирхлын зөрчилдөөний шуурганд дайрагдсан, хэт цөөн хүн амтай, бага буурай эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрх, хил хязгаарын халдашгүй дархан байдлын төлөө харийн дайсны өөдөөс халз тулан байлдаж амь бие үл хайрлан тулалдаж явсны эцэст хилс хирэгт гүтгэгдэн хохирсон ч бууж өгөөгүй эрэлхэг нисгэгчийн шонхорын зориг хэзээ ч мохоогүй юм.

Хожмын өдөр түүнд авах ёстой Монгол Улсын баатар цолыг нь Монголын төр нэхэн олгох нь тодорхой.

Баатар эр хэдий үхэвч байгуулсан гавьяа нь мөнх гэдэг билээ.



Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**

## ФОТО СУРВАЛЖЛАГА

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ ТОМИЛОЛТООС ИРЛЭЭ

# УЛАМЖЛАЛТ СОЁЛОО ХӨГЖИЛ ДЭВШИЛТЭЙ СҮЛЖ БУЙ ТӨВДҮҮД



Лхас бол Түвдийн нийслэл. Лхасын хүн ам одоогийн байдлаар 400 мянга орчим. Түвдийн өөртөө засах орны хувьд 3.3 сая хүн амтай. Тархан суурьшсан түвдчүүдээ хамруулвал долоон орчим сая гэж үздэг байна. ТӨЗО нь бүх хятад дотроо хамгийн нягтрал багатай бүс нутагт тооцогддог. Чин гүрний үед буюу 1734-1736 оны хүн амын тооллогоор 941.200 хүнтэй гэж гарч байжээ. Хожим нь 1953 оны тооллогоор 1 сая гаруй хэмээн тоологдож байсан бол 60 жилийн дараа хүн ам 3.3 сая болж өссөн байна.























*Түвд багачуудын хичээлийн нэг өдөр. Түвдийн сурагчид сургуульдаа 24 цагаар байрлаж суралцдаг. Дотуур байрандаа 4-6 хүүхэд байрлах ба орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон анги танхимд хичээллэдэг.*







*Түвдэд аялал жуулчлал өндөр хөгжиж буй нэг жишээ нь эдгээр гаршуулсан сармагчнууд юм.*

# ФОТО СУРВАЛЖЛАГА











*Лхас дахь Танка зургийн хүрээлэнг нь Төвдийн биет бус соёлын өвийг уламжлагч хадгалагч юм. Бурханы хөрөг бүтээх бүх явц тусгай дэг жаягтай аж.*
















*Дэд бүтэц нь гайхалтай хөгжиж буй Төвд.*

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +22
Шөнө +6

Нөгөөдөр
Өдөр +14
Шөнө +11

## Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өвчин ирнэ.*
**Наран ургах, шингэх:** *06.24-19.21*



Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лусыг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Цагаан шүүдэр буух улирал 19 цаг 53 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд



С. Лхагвабаяр

Хөгжилтэй хөгжилтэй хараал хэлж цочдог хүмүүс бас байх юм аа. Ажил дээр хүний даралт үзээд сууж байтал чагнуурны толгой ширээн дээрээс ойчоод, шал руу унаж час хийн дуугарав. Даралтаа үзүүлэхээр тэнгэр шиг тайван сууж байсан өвчтөн маань үсэрч босоод,

- ЭЭЭ МОГОЙН БОНДГОРОО гэж авсан.

Books “Ном” буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №149 дугаарт**

-Дэлт бүргэд чам руу дайраад байсан. Би чамайг мухлаг тэргэнд ачиж, өөрийн хүмүүсийн гэрт аваачиж нуусан билээ. Манайхны нэг домч чиний хавирга, хөлийг янзалсан юм.

-Тэгээд?

-Миний садан төрлийн хэдэн хүн тэргээр Кейптаун орно гэж байсан. Бид чамайг аваад явсан. Чи бараг цаг үргэлж ухаангүй байсан. Чамайг дахиад сэрэхгүй болов уу гэж айж байлаа.

Жеми өөрийг нь алах шахсан хүний нүдийг эгцлэн харав. Бодох юм ч их байлаа. Энэ хүнд итгэхгүй байлаа. Тэгтэл амийг нь аварчээ. Банда Жемиг ашиглан Ван Дер Мервегээс өшөөгөө авах гэж байгаа юм байна. “Энэ чинь надад бас хэрэгтэй юм” гэж Жеми бодов. Ван Дер Мерве хүний үнэргүй зан гаргасны хариугаа авах даа л авна гэж Жеми энэ дэлхий дээр юунаас ч илүү хүсч байлаа. Тэгээд Жеми

-За, сайн байна. Би Ван Дер Мервегээс хоёр биенийхээ төлөө өшөө авахдаа л авна гэлээ.

Энэ бүх үеийн турш Бандагийн царайд анх удаа инээмсэглэл илрэв.

-Тэр үхэх үү? гэж Банда асуухад

-Үгүй. Амьд байж байг гэж Жеми хэллээ.

Тэр өдөр Жеми орноосоо анх удаа босов. Хөл нь биеэ арайхийн дааж, толгой нь эргэж байлаа. Баруун хөл нь гүйцэд сайн эдгээгүй учир явахдаа жаахан доголж байв. Бандаг түших гэтэл

-Тавь, би өөрөө чадна гэлээ.

Өрөөн дотуур Жемигийн болгоомжтой явж байгааг Банда ажиглан харлаа. “Би лав их муухай харагдаж байгаа байх. Сахал үсээ хусаагүй хэд хоносон бол? Гэж Жеми бодоод

-Надад толь хэрэгтэй байна гэв.

Банда жижиг толь авчирч өгөхөд Жеми нүүрээ харвал өөдөөс нь огт үл таних хүн харж байлаа. Үс нь цав цагаан болжээ. Битүү сахал нь балиар муухай, хамар хугарч, мурийсан байв. Зүс царай нь 20 насаар хөгширчээ. Хацар нь хонхойж, үрчлээ суугаад дээд уруулын дор нь улаан тогтжээ. Нүдний харц нь хамгийн их хувирчээ. Энэ бол зовлон их үзсэн хүний нүд, үзэн ядахын гал гялалзсан нүд байлаа. Жеми толио алгуурхан буулгаад

-Би салхинд жаахан явья гэж Жемиг хэлэхэд Банда

-Уучлаарай, Макгрегор. Тэр болохгүй гэлээ.

-Яагаад?

-Энэ чин Кейптаун, хотын энэ хэсэгт цагаан арьстан орж ирдэггүй. Цагаан арьстаны хороололд хар арьстан юм. Чиний энд байгааг манай айл хөршийнхөн мэдэхгүй. Бид чамайг шөнө авчирсан.

-Тэгээд би эндээс яаж явах вэ?

-Чамайг өнөө шөнө эндээс аваад явна.

Бандагийн өөртөө хичнээн осолтой ажил хийж байгааг Жеми анх удаа л ойлгов. Тэгээд санаа зовж

-Надад мөнгө хэрэгтэй. Ажил олж хийх хэрэгтэй гэсэнд

-Би тэнгисийн боомтод ажил хийдэг. Тэнд хүн хэзээд хэрэгтэй гээд халааснаасаа мөнгө гаргаж

-Май, үүнийг ав гэхэд нь Жеми мөнгийг аваад,

-Би заавал буцааж төлнө гэсэнд

-Охин дүүгийн минь өшөөг авч өгвөл тэр чин өрөө төлж байгаа хэрэг гэж Банда хэллээ.

Шөнө дундын үед Банда Жемийг пингээс гаргав. Эргэн тойрон харвал байшингийн оронд хуучин муусайн пин, саравч шавааралдсан тосгоны гол дунд зогсож байв. Сая бороо орж шалбааг болсон гудамжнаас өмхий үнэр үнэртэнэ. Банда мэтийн ийм омог бардам хүмүүс яаж ийм газар амьдран сууж чаддагийг Жеми ойлгосонгүй.

-Ингэхэд...



-Чимээгүй. Манай айл хөршийнхөн их сониуч улс шүү гэж Банда шивгэнээд Жемийг тосгоноос авч гарлаа.

-Хотын төв тэнд бий. Хөлөг онгоцны засварын газрын тэнд уулзья.

Жеми Англиас анх ирсэн даруйдаа буусан мөнөөхөн зочид буудалдаа суух болов. Ширээний ард миссис Вентер сууж байлаа.

-Надад өрөө хэрэгтэй байна гэж Жемийг хэлэхэд авгай алтан шүдээ яралзуулан инээж

-Болно, эрхэм ээ. Намайг миссис Вентер гэдэг гэхэд нь

-Мэднэ гэсэнд авгай сэтгэл зовсон янзтай

-Та миний нэрийг яаж мэддэг юм бэ? Танил нөхөд чинь хэлээ юу?

-Миссис Вентер, та намайг танихгүй байна уу, би ноднин жил танайд буусан шүү дээ

Авгай Жемийн үрчгэр нүүр, муруй хамар, цав цагаан сахал үсийг анхааралтай ажин ширтээд:

-Би хүний зүс царай их сайн нүдэлж тогтоодог юм. Чамайг бол урьд огт зүс үзээгүй юм байна. Тэгэхдээ энэ бол бидний журмын сайн нөхөд болоход саад болохгүй. Тийм үү? Миний сайн нөхөд намайг Ди ди гэж дууддаг. Сайн эр чиний нэр алдар хэн бэ?

-Ян Тревис гэж хэлэх өөрийн дууг Жеми сонсов.

Жеми маргааш өглөө нь хөлөг онгоцны засварын газар ажилд орохоор очлоо.

-Бидэнд чадал тэнхээ сайтай хүн хэрэгтэй. Энэ ажилд чи дэндүү хөгшдөнө гэж даамал хэлэхэд нь

-Би дөнгөж19 тэй... гэж Жеми эхлэн дуугарснаа, толинд өөрийн дүрээ харснаа санан түгдэрч,

-Би ажил хийж чадна гэв.

Жеми өдөрт 9 шиллингийн хөлстэй ачигчийн ажилд оров. Боомтод ирсэн хөлөг онгоцонд ачаа ачих хэрэгтэй байв. Банда болон бусад хар арьстан ачигч нар өдөрт 6 шиллингийн хөлс авдагийг хожим мэджээ. Анх боломж таармагц Жеми Бандаг хажуу тийш аваачин

-Бидэнд ярих юм байна гэсэнд

-Энд болохгүй, Макгрегор. Хуучин агуулахад орой очоорой. Би ажил дуусаад тэнд очно.

Жемийг хоосон агуулахад очиход Банда тэнд хүлээж байлаа.

-Саломон Ван Дер Мервегийн тухай ярьж өгөөч?

-Чи юу мэдэхийг хүсээ вэ?

-Бүгдийг гэсэнд Банда газар нулимаад

-Тэр голландаас ирсэн юм. Миний мэдэхээр эхнэр нь маш царай муутай, баян хүүхэн байсан. Эхнэр нь нэг өвчнөөр үхсэн. Ван Дер Мерве эхнэрийнхээ мөнгийг авч Клипдрифтэд очиж дэлгүүр нээгээд эрэлчдийг мэхэлж баяжсан юм.

-Намайг мэхлэсэн шиг үү?

-Тэр чинь түүний олон аргын нэг нь юм. Азаар алмастай газар олсон эрэлчид тэр газар дээрээ шав тавихын тулд мөнгө зээлэх гэж Ван Дер Мерве дээр очдог юм. Тэднийг нүд ирмэхийн завдалгүй нөгөө алмастай газрыг Ван Дер Мерве худалдаад авчихсан байдаг.

-Түүнтэй тэмцэх гэж оролдсон хүн байхгүй юм уу?

-Тийм боломж бараг байдаггүй. Хотын түшмэл нь Ван Дер Мервегээс хахууль авдаг. Алмастай хэсгийг бүтэн хагас сарын турш хэнч ашиглаагүй бол түүнийг хэн дуртай хүн худалдан авч болно гэсэн хууль бий. Хотын түшмэл, Ван Дер Мервед хэрэгтэй мэдээ өгч, уг хэсгийг Ван Пер Мерве худалдан авдаг. Түүнд бас өөр нэг арга бий. Газар бүр зааг хязгаартай, буланд бүрд тэмдэг хадсан байх ёстой. Гадас унасан байвал тэр хэсэг газрыг хэн дуртай хүн худалдан авч болно. Аль нэг хэсэг газар түүнд аятайхан санагдвал шөнө тийш нь хүн явуулж өглөө болоход гадас нь хөсөр унасан байдаг юм.

-Ай тэнгэр...

-Ван Дер Мерве бас баарын эзэн Смит ярьж тохирсон байгаа. Смит гэнэн эрэлчдийг Ван Дер Мерве рүү явуулж, мань хүн хамжаа түнш болох тухай гэрээ байгуулж, түүний олсон бүх алмас Ван Дер Мервегийнх гэж заасан байдаг. Хэн нэг нь дургүйцэж эсэргүүцвэл Ван Дер Мервегийн гарын доорхи хүмүүс түүнийг дор нь номхотгодог юм.

-Үүнийг би мэднэ. Өөр юу мэдэх вэ?

-Тэр их сүсэг бишрэлтэй. Нүгэл хилэнцтэний сүнсийг аврах гэж залбирч байдаг.

-Маргеретын тухай юу хэлмээр байна даа?

-Мисс Маргерет уу? Эцгээсээ ухаангүй айдаг. Охин нь эр хүний өөдөөс харж зүрхэлсэн байвал өвгөн хоёуланг нь ална.

Жеми эргэж хаалга руу явахад тэндээс тэнгис харагдаж байлаа. Энэ бүхнийг сайтар эргэцүүлэн бодох хэрэгтэй юм.

-Маргааш дахиад ярилцья

Цагаан, хар арьстны хоорондуур ёроолгүй ангал нүх байдгийг Жеми Кейптаунд анх ойлгожээ. Хар арьстанд цагаан арьстны олгодгоос өөр эрх байхгүй. Хар арьстнууд өөрсдийн хороололд оршин суудаг, хэрэв цагаан арьстаны ажлыг хийж өгдөг бол тэндээсээ гарч явах эрхтэй байдаг.

-Та нар яаж ийм байдлыг тэвчдэг юм бэ? Хэмээн Жеми нэгэн удаа Бандагаас асуусанд

-Өлөн арслан хумсаа нуудаг юм. Хэзээ нэгэн цагт бид энэ бүхнийг өөрчилнө. Цагаан арьстанд бидний чийрэг булчин хэрэгтэй. Гэхдээ бидэнд бас тархи бийг тэд мэднэ. Цагаан арьстнууд биднийг хичнээн их хавчин харгислах тусам хэзээ нэгэн цагт өөрснөө ад үзэгдэж, гутамшиг болох ээлж ирнэ гэж айж байдаг. Цагаан арьстнууд ингэж бодоод яс нь хавталзаж байгаа. Бид “ исико” гийн ачаар тэсэж байдаг юмаа.

-Исико гэж хэн бэ? Гэсэнд Банда толгой сэгсэрч

-Хүн биш ээ. Үүнийг хариулахад хэцүү байна. Макгрегор. Исико гэдэг бол манай үндэс язгуур. Энэ бол аугаа их үндэстний хүн гэдгээ ухаарах сэтгэл. Энэ бол их мөрөн Замбезид нэр өгсөн их үндэстэн. Олон олон үеийн тэртээ миний өвөг дээдэс өөрийн хүмүүсийг өмнөө туун Замбези мөрний усан ордог байжээ. Хамгийн сул дорой нь усны эргүүлэгт орж үхэх юм уу, гүмбэрваа матрын аманд ордог байж. Амьд үлдсэн нь уснаас гарч ирдэг. Банту омгийн хэн нэг үхэхэд түүний гэрийнхнийг ой модонд оч гэж исико шаарддаг. Бусад хүмүүс тэдний уй гашууг хуваалцахын хэрэггүй гэснээс тэр. Исико бол боол мэт дуулгавартай байхыг жигшин зэвүүцэхийн нэр юм. Чи хэзээ нэгэн цагт Жон Тенго Жабавугийн тухай сонссон уу? Гэж Банда асуухдаа энэ нэрийг их л хүндэтгэлтэй өгүүлэв.

-Сонсоогүй.

-Сонсноо, Макгрегор. Заавал сонсоно гэж Банда өгүүлээд ярианыхаа сэдвийг өөрчлөв.

Жеми Бандаг улам их хүндлэх болов. Тэр хоёр бие биедээ итгэдэггүй байсан. Жеми өөрийг нь алах шахсан хүнд итгэж сурах хэрэгтэй болжээ. Банда бол өөрийн эртний дайсан цагаан арьстай хүнээс айхгүй байж дасах хэрэгтэй байлаа. Олонх хар арьстныг бодвол Банда эрдэм боловсролтой.

-Чи хаана сургуульд сурч байсан бэ, гэж Жеми асуухад

-Би сургуульд явж байгаагүй. Багаасаа ажил хийж байсан. Манай эмээ л надад юм бүхнийг зааж сургасан юм. Эмээ маань багш байлаа. Эмээ өөрөө уншиж бичиж сураад дараа нь надад зааж өгсөн юм. Эмээ маань их ачтай хүн шүү гэжээ.

Тэр бямба гаригт ээлжийн ажил дууссаны дараа Их Намаква ленд дах Намиб цөлийн тухай Жеми анх сонсчээ. Тэр хоёр хуучин муу агуулахад Бандагийн ээжийн хийсэн зээрний махан хуурга идэж суулаа. Мах нь жаахан эвгүй үнэртэй ч таваг дороо хоосров. Жеми овоолгоостой хуучин муусайн шуудайн дээр хэвтээд Бандагаас элдвийг асууж эхлэлээ.

-Чи Ван Дер Мерветэй хаана танилцсан бэ?

-Намиб цөлд алмас эрдэнэтэй газар ажил хийж байхдаа танилцсан. Ван Дер Мерве тэр газрыг хоёр хамжаа түнштэйгээ хамт эзэмшдэг. Ван Дер Мерве тэр түншийн холбоог нэг ядуу эрэлчнээс хулгайлаад өөрийн эзэмшил газрыг үзхээр ирсэн юм.

-Ван Дер Мерве тийм их баян юм бол дэлгүүрт ажиллахын хэрэг юу вэ?

-Дэлгүүр нь гэнэн эрэлчин барих занга байхгүй юу. Тийм аргаар эрэлчдийг мэхэлж аваачдаг. Тэгээд улам улам баяжиж байдаг. Жеми өөрөө Ван Дер Мервегийн дэгээнд хичнээн амархан орсноо санав. “Манай эцэг танд тусалж чадна” гэж Маргерет хэлж байсан нь нүдэнд үзэгдэж, чихэнд сонсогдох шиг боллоо. Жеми түүнийг хүүхдээрээ амьтан гэж бодож байснаа хөхийг нь хараад тийм биш гэж мэдэж билээ. Жеми гэнэт босон харайж, царайд нь баяр баясгалант инээмсэглэл тодров.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**

